

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр, Лхагва гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	27-67

---

<i>1.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2022.10.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	27-53
<i>2.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	53-57
<i>3.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	57-67

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны  
07 дугаар сарын 03-ны өдөр /Даваа гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 37 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Б.Жавхлан;  
Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Л.Мөнхбаатар, С.Одонтуяа,  
Ч.Хүрэлбаатар.*

*Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор,  
Ж.Батжаргал, Ш.Раднаасэд, Б.Чойжилсүрэн нар үг хэлэв.*

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасны дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл дээр эрх зүйн дүгнэлт гаргуулах горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 2  
Бүгд: 14  
85.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан/-ийн анхны хэлэлцүүлгийг дараагийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр түр хойшлуулав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллын нэгдүгээр асуудал болгон нэмж оруулах горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 3  
Бүгд: 14  
78.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа хэлэлцэх асуудлын дарааллын гуравдугаар асуудал болох Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн хэлэлцэх эсэхийг нэгдүгээр асуудал болгон хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 4  
Бүгд: 14  
71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

***Нэг.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2022.10.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Б.Болормаа, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн дэд Ерөнхийлөгч Ү.Галмандах, Татварын хөгжил дэвшил холбооны тэргүүн Б.Ганболд, мөн холбооны үйл ажиллагаа эрхэлсэн захирал В.Цэнд-Аюуш нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Л.Хурцбилэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн саналыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Х.Булгантуяа танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 2, 4-7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн дэд Ерөнхийлөгч Ү.Галмандах, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Х.Булгантуяа, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Б.Болормаа, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн С. Ганбаатар;

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Х.Булгантуяа, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Б.Болормаа, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн дэд Ерөнхийлөгч Ү.Галмандах нар тус тус хариулж, тайлбар хийв.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Г.Тэмүүлэн:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 7  
Бүгд: 12  
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**Г.Тэмүүлэн:** 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4.3 дахь заалтыг дор дурдснаар өөрчлөн найруулах:

4.3.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний хуулийн этгээд эрхэлнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** 1.Ажлын хэсгийн гаргасан Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

4.3.Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн татвар хариуцсан ажилтан нь татварын мэргэшсэн зөвлөх байна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 7  
Бүгд: 12  
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

6.1.7.татварын тайлангийн нийцлийг хянах, шинжилгээ хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 10.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

10.1.9.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 11.2, 11.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11.2.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн гишүүн байх бөгөөд татвар төлөгчийг татварын эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар татвар төлөгчдөд мэдээлэл өгөх үүрэгтэй.

11.3.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь даатгалын байгууллагаа өөрөө сонгож, мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 12.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

12.1.8.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, орон тооны татварын мэргэшсэн зөвлөх нь ёс зүйн зөрчилгүй талаарх Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолт гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 8

Бүгд: 12

33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 12.1.9, 10 дахь заалтын 18.2.9 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 14.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14.7.Татварын улсын байцаагчийн ажил, албан тушаалд 10-аас дээш жил ажилласан бол татварын албаны тодорхойлолтыг үндэслэн энэ хуулийн 15.1.3-т заасан хоёроос дээшгүй шалгалтаас чөлөөлж болох бөгөөд уг харилцааг татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох, сунгах журмаар зохицуулна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 16.1.7, 9 дэх заалтын 17.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

16.1.7.татварын хууль тогтоомж, түүний өөрчлөлт, татвар төлөгчийг татварын эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар татвар төлөгчдөд сурталчлан таниулах, мэдээлэл өгөх.

17.1.6.Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаал, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлсэн, хувь хүний орлогын албан татварын тайланг хуульд заасан хугацаанд гаргаагүй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 18.2.10 дахь заалтын “шаардлагын хэм хэмжээг” гэснийг “шаардлагын холбогдох журмыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 11.1.5 дахь заалтыг агуулгын хувьд нийцүүлэн, төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт руу шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11.1.5.тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан, эцсийн өмчлөгч өөрчлөгдсөн болон энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан мэдээлэл өөрчлөгдсөн бол энэ тухайгаа Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр мэдэгдэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3.1.3.“зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд” гэж татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөлийг гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын гарчиг болон 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **9 дүгээр зүйл.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд**

9.1.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.3-т заасан хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах бөгөөд зөвлөх үйлчилгээ эрхлэхдээ бусад татварын мэргэшсэн зөвлөхтэй гэрээгээр хамтарч ажиллаж болно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 10.1.1, 10.1.2, 10.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

10.1.1.эцсийн өмчлөгч нь татварын мэргэшсэн зөвлөх байх;

10.1.2.эрдэм шинжилгээ, сургалтын чиглэлээс өөр ажил давхар эрхэлдэггүй 2-оос доошгүй орон тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх;

10.1.8.хуулийн этгээд салбартай бол түүнд нэгээс доошгүй орон тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалтын 11.1.4 дэх заалт, 6 дахь заалтын 12.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11.1.4.үйлчлүүлэгчийн өмнөөс үйлдсэн, шалгасан татварын тайлан, холбогдох бусад баримт бичигт зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон орон тооны татварын мэргэшсэн зөвлөхийн эрхтэй албан тушаалтан гарын үсэг, эсхүл тоон гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах;”

12.2.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгох, сунгах бөгөөд энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 14.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14.5.Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг гурван түвшний зэрэглэлтэй олгох бөгөөд нэг, хоёрдугаар түвшний зэрэглэл тус бүрийг 5 жилийн хугацаагаар, гуравдугаар түвшний зэрэглэлийг хугацаагүй олгоно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын 15.1.1, 15.1.2, 15.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

15.1.1.их, дээд сургуулийг нягтлан бодогч, эдийн засагч, санхүүч мэргэжлээр болон татварын чиглэлээр бакалавр, түүнээс дээш зэрэгтэй төгссөн, эсхүл 5-аас доошгүй жил их, дээд сургуульд татвар, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр багшилсан, татварын асуудал эрхэлсэн төрийн байгууллагад ажилласан байх;

15.1.2.нягтлан бодогч, эдийн засагч, санхүүч мэргэжлээр болон татварын чиглэлээр 4-өөс доошгүй жил ажилласан байх;



15.1.4.зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч нь зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд давхар үүсгэн байгуулахгүй байх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Уг саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Булгантуяа хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь санал хураалт дээр гаргасан саналаа татан авч байгаагаа мэдэгдэв.

**Г.Тэмүүлэн:** 5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 12.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

12.1.8.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, орон тооны татварын мэргэшсэн зөвлөх нь ёс зүйн зөрчилгүй талаарх Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолт гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалтын 18.2.5, 18.2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

18.2.5. энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан этгээдийг мэргэжил, арга зүй, үйл ажиллагаандаа мөрдөх гарын авлага, татварын хууль тогтоомжийн талаарх мэдээллээр хангах, бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох мэдээллийг төрийн байгууллагад хүргүүлэх;

18.2.6.татварын тусгай мэдлэг бүхий шинжээчийг нийтэд мэдээлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 13.3 дахь хэсгийг агуулгын хувьд нийцүүлэн, төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

13.3.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн орон тооны татварын мэргэшсэн зөвлөх ёс зүйн зөрчил гаргасан талаарх Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолт болон бусад этгээдээс мэдээлэл ирсэн тохиолдолд тусгай

зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд түдгэлзүүлэх, хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг агуулгын хувьд нийцүүлэн төслийн 2 дугаар зүйл рүү шилжүүлж, “авахад” гэсний дараа “болон татварын мэргэшсэн зөвлөхийн эрхтэй холбогдсон харилцаанд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтыг агуулгын хувьд нийцүүлэн, төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт руу шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

12.1.6.хуулийн этгээд, түүний эцсийн өмчлөгч нь татварын өргүй талаарх тодорхойлолт гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн дагаж мөрдөх хугацааг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

**Г.Тэмүүлэн:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “4.3, 4.4 дэх заалт” гэснийг “хэсэг” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн “хэсэг” гэсний өмнө “зүйл,” гэж нэмж, төслийн 4 дүгээр зүйлд заасан “зөвлөх үйлчилгээ эрхлэх” гэсний ард тохиолдол бүрт “хуулийн” гэж нэмж, “мөн зүйлийн 11.1 дэх хэсэг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12

### 58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал 12 дахь саналтай холбогдуулан үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа ажлын хэсгийн гаргасан, 12.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын гарчиг болон 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **9 дүгээр зүйл.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд**

9.1.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.3-т заасан хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах бөгөөд зөвлөх үйлчилгээ эрхлэхдээ бусад татварын мэргэшсэн зөвлөхтэй гэрээгээр хамтарч ажиллаж болно гэсэн саналын санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан, 12.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын гарчиг болон 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **9 дүгээр зүйл. Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд**

9.1.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хязгаарлагдмал хариулагатай компани, нөхөрлөл байх бөгөөд бусад татварын мэргэшсэн зөвлөхтэй гэрээгээр хамтарч ажиллаж болно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын дарга Г.Тэмүүлэн Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг төслийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Х.Булгантуяа тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Х.Булгантуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг хариулж, тайлбар хийв.

**Г.Тэмүүлэн:** Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул,

референт Г.Нарантуяа, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Л.Хурцбилэг нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

***1.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8.1.1<sup>1</sup> дэх заалтын дугаарыг “8.1.2” гэж, мөн зүйлийн 3 дахь заалтын 8.4.7<sup>1</sup> дэх заалтын дугаарыг “8.4.8” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 10.5 дахь хэсгийн “санхүүжүүлэх, хянах, тайлагнахад төслийн кодыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчид бүртгэж, төсвийн төлөвлөлтөд тусгана” гэснийг “санхүүжүүлэх, хянах, тайлагнах болон төрийн болон орон нутгийн өмчид бүртгэхдээ төслийн кодыг үндэслэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн, хэсгийн дугаарыг “11<sup>1</sup> дүгээр зүйл” болгон өөрчлөх:

**“11<sup>1</sup> дүгээр зүйл.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн  
Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

11<sup>1</sup>.1.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 12<sup>2</sup>.1-д заасны дагуу боловсруулсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 12.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн, хэсгийн дугаарыг “12<sup>2</sup> дугаар зүйл” болгон өөрчлөх:

**“12<sup>2</sup> дугаар зүйл.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

12.1.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 24.7 дахь хэсгийн “өмчийн оролцоотой” гэсний өмнө “, төрийн болон орон нутгийн” гэж, мөн хэсгийн “ногдох хөрөнгийг” гэсний өмнө “болон орон нутагт” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 27.1.10 дахь заалтын “ирээдүйн өв сангийн дансны үлдэгдлийн мэдээллийг” гэснийг “Ирээдүйн өв сангийн үлдэгдлийн хэмжээг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 7

Бүгд: 12

41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** 6.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 27.1.10 дахь заалтын “ирээдүйн өв сангийн дансны үлдэгдлийн мэдээллийг” гэснийг “Ирээдүйн өв сангийн үлдэгдлийн хэмжээг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1.2</sup> дахь хэсгийн “жил бүрийн 3, 8 дугаар сард багтаан” гэснийг “8 дугаар сард, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1.2.1</sup> дэх заалтын “асуудал” гэсний өмнө “салбарын” гэж нэмэн, 28<sup>1.2.2</sup> дахь заалтын “нийгмийн халамж, эрүүл мэнд, дэд бүтэц, байгаль орчин зэрэг” гэснийг болон 28<sup>1.2.3</sup> дахь заалтын “зэрэг шинжтэй” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1.3</sup> дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28<sup>1.3</sup>.Энэ хуулийн 28<sup>1.2</sup>-т заасан төсвийн тодотголд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэлээр боловсруулах төсвийн тодотгол хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1.4</sup> дэх хэсгийн “төсөл, түүний нэмэлт, өөрчлөлтийн” гэснийг хасаж, “3 дугаар сард багтаан энэ хуулийн 28<sup>1.1</sup>-д заасан журмаар” гэснийг “3 дугаар сард багтаан, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд энэ зүйлд заасан журмаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалт буюу 32.2.22 дахь заалтын “шийдвэрлэсэн талаар танилцуулгад тусгана.” гэснийг “тусгасан талаарх мэдээлэл;” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсгийг хасаж, 70.2 дахь хэсгийн “гүйцэтгэх удирдлага болон холбогдох” гэснийг “удирдах болон гүйцэтгэх” гэж, мөн хэсгийн “28<sup>1.3</sup>” гэснийг “28<sup>1.4</sup>” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн “28.3.8” гэсний дараа “, 28.3.12” гэж,” гэснийг хасаж, ““санхүүжилтийн эх үүсвэрээр” гэсний дараа “анхны төсөвт өртөг, код” гэж” гэснийг ““төсөвт өртөг,” гэсний дараа “анхны төсөвт өртөг,” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 55 дугаар зүйлийн 55.4.2 дахь заалтын “ирэх” гэсний өмнө “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 8.1.1, 8.4.3, 8.4.4, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг” гэснийг “дараах хэсэг, заалтыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8



Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 8.1.1 дэх заалтын “боловсруулсан” гэснийг “ирүүлсэн” гэж, “дүн шинжилгээ, тооцоонд” гэснийг “таамаглалд” гэж тус тус өөрчлөн, 2 дахь заалт буюу 8.4.3 дахь заалтын “, шаардлагатай тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл тухайн жилийн төсөвт баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг тус тус боловсруулж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 8.4.4 дэх заалтын “холбогдох макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тулгуурлан нэгтгэн боловсруулж, хөгжлийн бодлогын баримт бичигт нийцсэн эсэхэд эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж” гэснийг “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн нэгтгэн боловсруулж, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “10-ны” гэснийг “9-ний” гэж өөрчлөн, “8.4.3 дахь заалтын “8 дугаар сарын 15-ны” гэснийг “07 дугаар сарын 25-ны” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “чуулган эхлэх өдрөөс эхлэн хэлэлцэн” гэснийг “чуулганаар хэлэлцэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “28 дугаар зүйлийн” гэснийг “28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн “28.3.8-д” гэснийг “ 28.3.8, 28.3.12-т” гэж, мөн зүйлийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “28.2,” гэснийг хасаж, “28.1” гэснийг “29.1” гэж өөрчлөн, “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “8 дугаар зүйлийн 8.1.2-8.1.4 дэх заалтын дугаарыг “8.1.3-8.1.5” гэж, 8.4.8 дахь заалтын дугаарыг “8.4.9” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн “хэсгийг” гэснийг “заалтыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

***2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “түүний” гэснийг хасаж, “кодоор” гэснийг “бүрийн код” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

***3.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хэлэлцээр батлахаас” гэснийг “хэлэлцээрээс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “38.8 дахь” гэснийг “38.9 дэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 75<sup>1</sup> дүгээр 75<sup>1</sup>.3.1 дахь заалтын “зээлийн зориулалт нь” гэснийг “зээлийн зориулалтыг тодорхой тусгасан эсэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 75<sup>1</sup> дүгээр 75<sup>1</sup>.3.2 дахь заалтын “төсөл, арга хэмжээг хөгжлийн зорилтот хөтөлбөртэй нийцсэн эсэх” гэснийг “төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан, тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн төсөл, хөтөлбөр байх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 75<sup>1</sup> дүгээр 75<sup>1</sup>.3.3 дахь заалтын “Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан төсөл, арга хэмжээ нь эдийн засгийн бодит өсөлтийг нэмэгдүүлэх” гэснийг “улс орны нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, импортыг орлох болон экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт болон зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэгдсэн байх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 75<sup>1</sup> дүгээр 75<sup>1.3.4</sup> дэх заалтын “нөлөөлөхгүй” гэсний дараа “, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**5.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**6.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**7.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт” гэсний өмнө “хэсэг,” гэж нэмэн, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 6.4.8 дахь заалтын “зардлын хяналтыг” гэснийг “гүйцэтгэлийн хяналтыг” гэж өөрчлөн, 3 дахь заалт буюу 6.5.3 дахь заалтын “хэлэлцээр” гэсний өмнө, 5 дахь заалт буюу 13.2.5 дахь заалтын “хэлэлцээрийн” гэсний өмнө “гэрээ,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6.5.4 дэх заалтын “Монгол Улс шинээр зээл авах” гэснийг “энэ хуульд заасны дагуу улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгаанд хамаарах зээл авах” гэж, мөн заалтын “зэрэг мэдээллийг нэгтгэсэн байдлаар” гэснийг “зэргийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 18.11 дэх хэсгийн “тооцоолол” гэснийг “тооцоо, судалгаа” гэж өөрчлөн, “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн” гэсний өмнөх “Монгол Улсын Шадар сайд,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “13.2.3” гэснийг “13.2.2” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “тогтоосон” гэсний өмнө “талаар” гэж, “дэлгэрэнгүй” гэсний өмнө “талаарх” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

***8.Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хэсэг” гэсний дараа “, заалт” гэж нэмэн, мөн зүйлийн 1 дэх заалт буюу 8.8 дахь хэсгийн “Монгол Улсын нэгдсэн төсвийн” гэснийг “Нэгдсэн төсвийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн ““өргөн мэдүүлсэн” гэснийг “өргөн мэдүүлэх” гэж” гэснийг “Монгол Улсын жилийн төсвийн” гэсний болон “жилийн төсвийн төсөлд” гэсний өмнөх “өргөн мэдүүлсэн” гэснийг “өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**9.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “, заалт” гэснийг хасаж, мөн зүйлийн 1 дэх заалт буюу 6.5 дахь хэсгийн “эцсийн хугацааг” гэснийг “хугацааг” гэж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 7.5 дахь хэсгийн “3 сараас доошгүй хугацаанд төсвийн төсөл” гэснийг “гурваас доошгүй сарын хугацаанд жилийн төсвийн төсөл” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7.6 дахь хэсгийн “Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гамшиг бүхий нөхцөл байдал бий болж төсөв болон” гэснийг “Гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаварыг арилгах зорилгоор жилийн төсөв болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7.7 дахь хэсгийн “хэлэлцэх Улсын Их Хурлын Байнгын хорооны хуралдаан болон нэгдсэн чуулганд нийт гишүүн хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно.” гэснийг “хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.20-д зааснаас бусад тохиолдолд чуулганы хуралдаанд товлосон хугацаанд заавал хүрэлцэн ирж оролцоно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16<sup>1</sup>.1 дэх хэсгийн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн” гэснийг “улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний” гэж, “үзүүлэлтийн төсөөллийг” гэснийг “үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 зүйлийн 4 дэх заалт буюу 16<sup>1</sup>.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16<sup>1</sup>.2.Зөвлөл нь 7 гишүүнээс бүрдэх бөгөөд Төсвийн байнгын хороо нээлттэй сонгон шалгаруулалтаар хүн тус бүрээр шалгаруулж, Улсын Их Хурал энэ хуульд заасан журмын дагуу томилж, чөлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16<sup>1</sup>.3.2 дахь заалтын “идэвхтэй” гэснийг, 16<sup>1</sup>.3.3 дахь заалтын “улс төрийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16<sup>1</sup>.4.4 дэх заалтын “үр дүнгийн талаар сонсгол зохион байгуулж хамгийн өндөр үнэлэмж авсан” гэснийг “үр дүнд хамгийн өндөр үнэлгээ авсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэн, үүнтэй уялдуулан 16<sup>1</sup>.4.5, 16<sup>1</sup>.4.6, 16<sup>1</sup>.4.7, 16<sup>1</sup>.4.8 дахь заалт, 16<sup>1</sup>.5, 16<sup>1</sup>.6 дахь хэсгийг тус тус хасах:

“16<sup>1</sup>.4.5.Төсвийн байнгын хороо нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29, 30, 31 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-127 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16<sup>1.8</sup> дахь хэсгийн “Төсвийн байнгын хорооны шийдвэрээр” гэснийг “Улсын Их Хурал” гэж, 16<sup>1.9</sup> дэх хэсгийн “үзүүлэлтийн тооцоолол” гэснийг “үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг” гэж тус тус өөрчлөн, уг хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“16<sup>1.6.7.бүрэн</sup> эрхийн хугацаа дуусгавар болсон.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16<sup>1.11</sup> дэх хэсгийн “тогтоох итгэлцүүрийг” гэснийг болон 16<sup>1.12</sup> дахь хэсгийг тус тус хасаж, 16<sup>1.3.7</sup> дахь заалтын дугаарыг “16<sup>1.10.</sup>” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “үзүүлэлтийн төсөөлөлд” гэснийг “үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

***10.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

***11.Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “8 дугаар зүйлийн 8.3 дахь” гэснийг “8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.5 дахь” гэж өөрчлөн, 8.3 дахь хэсгийн “дансанд” гэсний дараа “Сангийн эх үүсвэрийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.



Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “10.7, 10.8,” гэснийг “10 дугаар зүйлийн 10.8, 10.9 дэх хэсэг” гэж, мөн зүйлийн “24.15.5” гэснийг “25.14.5” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**12.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** 1.Төсвийн байнгын хороо гаргасан Төслийн 1 дүгээр зүйлийн “5, 16, 21 дүгээр зүйлд хуульд доор дурдсан агуулгатай хэсэг” гэснийг “хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 6  
Бүгд: 12  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** 1.Төсвийн байнгын хороо гаргасан Төслийн 1 дүгээр зүйлийн “5, 16, 21 дүгээр зүйлд хуульд доор дурдсан агуулгатай хэсэг” гэснийг “хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт буюу 5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “зэргээр аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг,” гэснийг “түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг” гэж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “төсвийн алдагдал нөхөх зэрэг аливаа хөтөлбөр, арга хэмжээг” гэснийг “болон төсвийн алдагдлыг” гэж тус тус өөрчлөн, мөн хэсгийн болон 3 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21 дэх хэсгийн “тусламж” гэсний дараа “, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ,” гэж тус тус нэмэн, 21 дэх хэсгийн “төсвийн алдагдал нөхөх зэрэг аливаа хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг” гэснийг “төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

***13.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах, төсвийн цаглаврыг мөрдүүлэхтэй холбогдсон зүйл, хэсэг заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

***14.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:***

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын “16<sup>1</sup>.4 дэх” гэснийг “16<sup>1</sup> дүгээр зүйлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 50 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.5 хувийн ирцтэйгээр 12 цаг 27 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр,  
Даваа гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
09 цаг 37 минут.

### **ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүдэд энэ өглөөний мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Нэгдүгээрт,  
Хавдисламын Баделхан, Жигжидийн  
Батжаргал, Жамбын Батсуурь,  
Салдангийн Одонтуяа, Дамдинсүрэнгийн  
Өнөрболор, Бөхчулууны Пүрэвдорж,  
Шадарбалын Раднаасэд, Цэндийн  
Сандаг-Очир, Дуламдоржийн  
Тогтохсүрэн, Баттогтохын  
Чойжилсүрэн нарын гишүүд хүрэлцэн  
ирснээр өнөөдрийн Байнгын хорооны  
хуралдааны ирц бүрдсэн тул 2023 оны 7  
дугаар сарын 3-ны өдрийн хуралдаан  
нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар  
хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг, Аж ахуйн нэгжийн орлогын  
албан татварын тухай хуульд нэмэлт  
оруулах тухай хуулийн төсөл, Засгийн  
газар 6 сарын 2-ны өдөр өргөн  
мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг байгаа.

Гаалийн тариф, гаалийн  
татварын тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.  
Мөн 6 сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
эцсийн хэлэлцүүлэг.

Гуравт, Хууль баталсантай  
холбогдуулан арга хэмжээний тухай  
Монгол Улсын Их Хурлын тогтоол,

Төсвийн байнгын хороо боловсруулсан,  
анхны хэлэлцүүлэг.

Дөрөвт, Төсвийн тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн  
төсөл болон хамт өргөн мэдүүлсэн  
төслүүд байгаа. Анхны хэлэлцүүлэг.

Тавд, Татварын мэргэжсэн зөвлөх  
үйлчилгээний тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.  
Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар  
2022 оны 10 сарын 5-ны өдрийн өргөн  
мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж  
саналтай гишүүд байна уу. Өнөрболор  
гишүүн.

**Д.Өнөрболор:** Энэ хуулийг,  
хуулийн талаар бол би эхнээс нь л санал  
гаргаад ерөөсөө огт ёстой барахгүй  
байгаа нөхцөл байдалтай байгаад байна.  
Ер нь анхны хэлэлцүүлэг дээр энэ Улсын  
Их Хурлын гишүүнийхээ эрхийг эдэлж  
чадаагүйдээ бол би маш сэтгэл дундуур  
байгаа. Ер нь энэ дэгийн хуулиараа анхны  
хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй  
санал гаргах, мөн юу гэдэг юм энэ  
саналыг бүхэлд нь эсвэл энэ хуулийн зүйл,  
заалт дээр бол тодорхой хэмжээний  
өөрчлөлт оруулах ийм боломж нь өөрөө  
нээлттэй байгаа. Тухайн энэ асуудалтай  
холбоотойгоор.

Тэгээд Байнгын хорооны дарга та  
хүлээж аваагүйгээс болоод энэ санал  
хураалгалгүйгээр ингээд өнгөрсөн байж  
байгаа. Ер нь би яагаад энэ асуудал дээр  
ингэж их ач холбогдол өгөөд байна вэ  
гэдгийг би бас гишүүддээ бас хэлэх нь  
зүйтэй гэж бодож байна. Өнөөдөр  
Засгийн газар Улаанбаатар хотын  
агаарын бохирдлыг 80 хувь хүртэл  
бууруулна гэдэг амлалтыг өгсөн.

Гэтэл өнөөдрийн орж ирж байгаа  
энэ хууль өөрөө “Шинэ сэргэлтийн  
бодлого”-ын ард зэрэгцээд Улаанбаатар  
хотод түүхий нүүрсний утаа үйлдвэрлэх  
ийм бодлого давхар орж ирж байгаа  
учраас би энийг эсэргүүцээд байгаа юм.

Тэгээд Чойжоо сайдад ингээд хэлэхлээр ингээд доромжлоод, уурлаад байх юм.

Ер нь би бол бодохдоо энэ дээр нэгдүгээрт зарчмын зөрүүтэй санал гаргах бол боломж байсан. Тэгээд боломжийг бол ерөөсөө эдлүүлэлгүй Байнгын хорооны дарга асуудлыг ингээд өнгөрөөчхөж байгаа юм. Ямар эрх ашиг, сонирхол байгаа юм би ойлгохгүй байна. Энийг би юу гэж бодсон бэ гэхээр дараа нь ингээд ярилцаж байна гээд тэгэхлээр дэгийнхээ хуулиар энэ дагаж мөрдөх журмын хуулийг боловсруулаад ингээд хуульд бас тодорхой хэмжээний өөрчлөлт оруулах ийм боломж нь байна гээд тэгсэн.

Тэгээд тэрийг бол байхгүй зүгээр тогтоолоор ингээд асуудал байж. Тэгээд би энэ тогтоолыг бол бас ахиад дэмжиж чадахгүй байгаа нь юу гэж байна гээд тэгэхлээр манай улсад өнөөдөр энэ хууль тогтоомжийн хэрэгжилт маш муу байдаг, гүйцэтгэл дээрээ очоод бол ерөөсөө унаж байдаг ийм бичиг, баримтыг бол би хувьдаа яг ний нуугүй хэлэхэд хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм.

Дээрээс нь энэ бид нар ингээд Чойжоо сайд яг энэ шийдвэр, энэ хуулийн төслийг оруулж ирж байгаа асуудал нь өнөөдөр Үндсэн хуулийг зөрчиж байгаа гэдгийг та түүнээс бүүр маш сайн мэдэж байгаа. Би мэдэх ёстой гэж бодож байгаа. Энэ Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-ын эсрэг та ард иргэдийнхээ эсрэг гэмт хэрэг үйлдэж байгаа ийм л нөхцөл байдалтай байгаа шүү. Тэгээд би энийг гишүүд, эсвэл ямар хуулийн боломж байгаа юм. Миний хувьд бол энэ гэмт хэргийг үйлдэхийг хүсэхгүй байна.

Нэн ялангуяа хотын энэ гишүүд ч гэсэн энийг анхааралдаа авах нь зүйтэй. Энэ Раднаасэд гишүүн ч гэсэн энэ хажууд энэ боломж нь байгаа, хуулиараа энэ өөрөө өгөгдөл, боломж нь байгаа гээд байхад чинь миний эрхэнд ингээд халдаад байгаа байхгүй юу. Тэгээд би

энэнээс, энэ хуулиас гарч байгаа үр дагавар нь маш ноцтой, бодит амьдрал дээр маш ноцтой учраас л би энийг эсэргүүцээд байгаа юм.

Тэгээд би энийг хэрэв үнэхээр юу гэдэг юм, та бүгдийг бас энэ дээр ингээд зөв талаас нь хандаасай. Үнэхээр босгож болох боломжтой байх юм бол тэр 2/3-оор тэгээд босгох тэр боломжийг нь бүрдүүлэх, эсвэл Хууль зүйн байнгын хороогоор энэ хуультай холбоотой ямар нэгэн дүгнэлт гарсан юм уу.

Ер нь бүх энэ хууль тогтоомжууд Засгийн газраар орж хэлэлцүүлэхийнхээ өмнө угаасаа Хууль зүйн байнгын хорооноос энэ энэний өөрийн гарах үр дагавар, сөрөг нөлөөлөл, бүх зүйл дээр Хууль зүйн байнгын хорооноос уул нь.../минут дуусав./

**Г.Тэмүүлэн:** Өнөрболор гишүүн та хэлэлцэх асуудалтай холбогдуулж сая санал бол Өнөрболор гишүүнээ таны саналыг яагаадахъя, хэлэлцэх асуудалтай холбогдуулаад Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль дээр нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Үндсэн хууль зөрчсөн гэдэг асуудлаар дүгнэлт гаргуулах гэж байна уу. Саяын оруулж ирж байгаа Засгийн газрын хуулийн төсөл нь.

Тэгэхээр та томъёоллыг нь, эсвэл юу гэдэг юм саяын хэлэлцүүлгийн явцад хууль хоорондын зөрчил гэдэг асуудлаар уу, алинаар нь дүгнэлт гаргуулахаар санал өгч байна. Тэгэхээр бид нар яг таны хэлсэн саналын дагуу холбогдох байгууллагаар нь хууль зүйн дүгнэлт гаргуулах шаардлагатай болчихоод байгаа юм.

Тэгээд хэрэв дүгнэлт гаргах хүртэл бол хугацаагаар тэр хуулийн хэлэлцэх асуудлыг бол Байнгын хорооны даргын хувьд бол хойшлуулж болно. Тухайн үед таны гаргасан саналын томъёолол бол бид нарт ирсэн. Тэгээд энэ бол Дэгийн хуулийн 40.3-ын, байж байгаарай одоохон би юуг нь уншаадахъя.

Дэгийн тухай хуулийн 40.3.7-гоор хуулийн төслийн заалтын үг, өгүүлбэрийн дараа бие даасан агуулга бүхий үг, өгүүлбэр нэмэх нь хориотой байна гээд энэ таны гаргасан саналыг бол хэлэлцүүлээгүй байгаад байгаа.

Тэгэхээр та саяын таны гаргасан санал хууль хоорондын зөрчлийг үүсгээд байна уу, эсвэл Үндсэн хуулийн зөрчил үүсгээд байна уу гэдэг дээр та бас зарчмын зөрүүтэй санал, хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналаа гаргаач гэх гээд байгаа юм. Аль байдлаар нь дүгнэлт гаргуулахаар яах вэ. Тийм, сая бол бид нар хэлэлцэх асуудлынхаа дарааллыг батлах гээд байна шүү дээ. Тэгэхээр та хэлэлцэх асуудлын дараалал дээрээс нэгдүгээрт энэ дүгнэлт гаргуулахтай холбогдуулж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн төслийг хэлэлцэхийг нь хойшлуулъя гэсэн санал гаргах гээд байна гэсэн үг гэж ойлголоо. Зөв үү.

Өнөрболор гишүүн.

**Д.Өнөрболор:** Тийм. Миний хувьд бол үндсэндээ ингээд л байгаа шүү дээ. Түүхий нүүрс түлэхээ больё хотод. Энийг байна шүү дээ “Шинэ сэргэлтийн бодлого”-ын агуулгын хүрээнд хөдөө орон нутагт ч байдаг юм уу, эсвэл юу гэдэг юм бодлогын хүрээнд Аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд бол боломжтой. Хотод энэ түүхий нүүрс түлэх асуудлыг ерөөсөө ялгамжтай байдлаар оруулж өгье.

Тэгээд энэ хууль тогтоомжийн энэ Засгийн газраар оруулж байгаа энэ хуультай холбоотойгоор би бол энэ Үндсэн хуулийн энэ сөрөг үр дагавар, дээрээс нь ингээд л энэ Агаарын бохирдлын үндэсний хорооны хийж буй, хэрэгжүүлж байгаа ажлууд дээр дүгнэлт гаргаад ямар нэгэн байдлаар энэ хууль орж ирэх ёстой асуудал байгаад байгаа байхгүй юу нэг талаасаа Тэмүүлэн гишүүнээ.

Нөгөө талаасаа гээд тэгэхлээр, нөгөө талаасаа гээд тэгэхлээр энэ байна шүү дээ их тийм зальтай хууль байгаад байгаа юм. Энэ том бодлогын ард байна шүү дээ давхар маш их олон юм нуугдаж орж ирээд байгаа байхгүй юу. Тэгээд яаж байна гээд тэгэхлээр ерөөсөө 300-аад, Чойжоо гишүүний тайлбарлаж байгаагаар угаасаа ч тийм. Би бас тэр техникийнх нь нөхцөлийг мэдэж байна. 1.5 мегаватт гэдэг 200-300 айлын хэрэглээ. Энэ хэрэглээг хангах хэмжээний үйлдвэрлэл. Тэгээд энэ яндан өнөөдөр 300-аад мянган айл өрх өнөөдөр сайжруулсан шахмал түлш хэрэглэж байх энэ цаг үед одоо яаж байна вэ гээд тэгэхлээр түүхий нүүрс оруулж ирье, яндангаа 1000 болгоё гээд өнөөдөр бүгдийг нь хордуулж алах гэж байна шүү дээ. Тэгээд энэ дээрээс нь Агаарын бохирдлын үндэсний хороогийн авч хэрэгжүүлсэн маш их олон шат дараалсан арга хэмжээнүүдийн эсрэг ийм ухрах бодлого бид нар баримталж байна шүү дээ. Тэгээд энэ өнөөдөр бол асуудал хүмүүсийн анхааралд орохгүй байж магадгүй.

Гэхдээ намар бол энэ бол тэсрэх бөмбөг шиг асуудал үүснэ шүү. Би энийг гишүүдэд маш их анхааруулаад л хэлээд байгаа юм. Энийг дэмжиж байгаа гишүүд ч гэсэн энэ бол ерөөсөө бараг энэ хуулийн ард явж байгаа энэ гэмт хэрэгтэй холбоотой асуудал үүсэж байгаа юм шүү гэдгийг бол би та нарт бас анхааруулаад хэлчихье гэж бодож байна.

Тэгээд энэ юу шүү дээ. Наад гаалийн татвар ч гэсэндээ өнөөдөр байна шүү дээ ялгамжтай хэлбэрээр байх ёстой байхгүй юу. Энэ ногоон технологийг дэмжих гээд байгаа юм уу, гүний дулааныг дэмжих гээд байгаа юм уу, эсвэл шахмал нүүрсний станцыг дэмжих гээд байгаа юм уу, эсвэл түүхий нүүрсний станцыг дэмжих гээд байгаа юм уу. Маш ялгаатай зүйл шүү. Энэ хуулиар бол бүх юм нээлттэй болж байна. Бүх боломж нээлттэй болж байгаа гэдгийг, нээлттэй боломж гэдэг

маань юу гэж байна гээд тэгэхлээр хамгийн өртөг бага аж ахуйн нэгжүүд зөвхөн 10 хувиа төлөөд 10 хувиа төлөөд түүхий нүүрсний станцууд барьж байгуулна л гэсэн үг. Улаанбаатар хотод. Ингээд 1000 яндантай бид нар бүгдээрээ хордож унах, үхэх ийм л аюул учирчхаад байгаа учраас би энэний эсрэг яваад байгаа юм гэдгийг би бас хэлмээр байгаад байгаа байхгүй юу.

**Г.Тэмүүлэн:** Тэгээд хууль зүйн дүгнэлт гаргуулах асуудлаар санал хураалгая гэсэн үг. Тэгэхээр нөгөө энэ өргөн баригдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болоод Гаалийн тарифын татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ хуулийн төслүүд Үндсэн хууль болоод бусад холбогдох хуультай зөрчилдөж байна гэсэн асуудлаар хуульд эсэх асуудлаар хууль зүйн дүгнэлт гаргуулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалгах нь байна шүү дээ тээ.

Батжаргал гишүүн горимын санал гаргах нь уу.

**Ж.Батжаргал:** Үгүй үгүй. Хэлэлцэж байгаа асуудал дээр хэн нэгэн рүүгээ янз бүрийн юм дайраад хэрэггүй яг нарийндаа. Хэдүүлээ зөв л учир зүйгээ олж, зөв шийдэл гаргах ёстой. Энд биднүүс эх үүсвэрийн хүчин чадлын тухай ярьсан болохоос биш шахмал түлшний, түүхий нүүрсний нэг ч юм яриагүй. Энэ асуудлаа дагасан хууль тогтоомжоороо гэдэг юм уу, тодорхой бүс дээрээ зохицуулалт хийсэн шийдэл нь байгаа шүү дээ. Энэ Улаанбаатар хотын нам даралтын гэдэг юм уу, жижиг оврын зуухнуудыг бүгдийг нь сайжруулсан түлшний хэлбэр рүү шилжүүлж гээд Засгийн газраас тэр Агаар орчны бохирдлын хорооноос чинь шийдэл гаргаад тэр рүүгээ яваад байгаа биз дээ. Тэр л шийдлээрээ шийдэгдэнэ шүү дээ. Энд бол биднүүс зөвхөн үйлдвэрлэх эх үүсвэрийн доод хүчин чадлын тухай л ярьсан. Тэрнээс биш энд ямарваа нэгэн хэрэглээний цаад түлшнийх нь чанарын тухай юм яриагүй

шүү. Би тэр өнцгөөс нь харж яриад байгаа юм наадхад чинь.

**Г.Тэмүүлэн:** Раднаасэд гишүүн горимын санал гарах юм уу.

**Ш.Раднаасэд:** Хоёр боломж байна. Эс үгүй бол дүгнэлт гаргуулна гээд тэрийгээ яг бичиж өгөх хэрэгтэй. Яг ийм ийм ийм асуудлаар гээд. Яг энэ асуудлаар гэдгээ тэгээд санал хураана санал хураана.

Хоёр дахь нь бол 39-өөр батлахад нь батлахгүй гэж шийдвэр гарах юм бол Засгийн газар шууд буцна. Одоо эцсийн, маргааш 5 дахийн өглөө яадаг. Тийм 5 дахь өдөр. 39 гишүүн дэмжээгүй бол буцсанд тооцно гэсэн ийм 2 л юу байна. Үгүй үгүй би эцэслэн батлах дээр ярьж байна шүү дээ. Тэр дээр наадах чинь дэмжсэн үү, дэмжээгүй юү огт хамаагүй.

Ер нь энэ Өнөрболор гишүүний гаргасан энэ тайлбар энийг зүгээр л саналыг нь хураагаад л явчих газар байхгүй юу. Үйлдвэрлэх гэдэг нь Улаанбаатар хотод хамаарч байгаа тэр тоног төхөөрөмж дээр чинь татвар дээр хамаагүй юм гээд гээд л явчихсан бол өнөөдөр ийм байдал үүсэхгүй байхгүй юу.

Сайд, гишүүн хоёрт мэтгэлцэх бас боломж байгаа. Хэн хэнийх нь зөв бэ гэдгээ. Энэ дэгийн хуулийн энэ заалтыг ерөөсөө гишүүд хэрэглэхгүй байгаа байхгүй юу. Би Тавинбэх сайдтай нэг удаа хэрэглэж байсан юм. Энэ 30 минут хүртэл зөвхөн хоорондоо хэнийхээ зөв бэ гэдэг энэ гишүүд ихэнх гишүүд нь бол юмаа ойлгохгүй энэнийх нь Чойжилсүрэн сайдын зөв үү, Өнөрболор гишүүний зөв үү гэдэг ийм юман дээр оччихож байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хоёр хүний чинь яриад байгаа санал нь аль нь. Батжаргал гишүүн бүүр гурав дахь ч юм яриад байна шүү дээ. Энэ бол бүүр түүхий нүүрс биш бүүр шал өөр юм байгаа юм гээд. Энэ

мэтчилэн энэ ойлголтын зөрүүгээ цэгцэлж аваад энэ гишүүд 39-өөр санал хураалгахад бэлэн болохын тулд мэтгэлцэх ийм боломж бас байгаа.

**Г.Тэмүүлэн:** Чойжилсүрэн гишүүн та горимын санал гаргана шүү. Яг тодорхой санал гаргана.

**Б.Чойжилсүрэн:** Тэмүүлэн дарга баярлалаа үг өгсөнд. Гишүүдийнхээ энэ өглөөний амрыг эрвэ нэг.

Хоёрдугаарт ийм Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн ийм дэг байгаа бол Өнөрболор гишүүн бид хоёр хамаагүй мэтгэлцье. Би тэр мэтгэлцээнээс зугтаагаад байх юм алга. Энэ хуулийн төсөл тийм мундаг их сайн хуулийн төсөл биш. Аргаа барахдаа л оруулж ирж байгаа юм.

Тэгээд нөхцөл байдал, одоо жишээлбэл бид нар бодит байдалтайгаа нүүр тулах нь үнэн. Улаанбаатар хотын Тэц-II, Тэц-III Тэц-IV дээр бид нар 4 сая гаруй тонн 4 сая гаруй тонн шүү түүхий нүүрс түлж байгаа. Үргэлжлүүлээд түлэхээс ондоо аргагүй. Түүнийг би Өнөрболор гишүүний асуултад хариулахдаа хариулсан. Өнөрболор гишүүн сүүлдээ бүүр Үндсэн хуулийн харилцаа болоод яваад өгөх бололтой. Бас нэлээн асуудлаасаа хөндийрөөд.

Тийм учраас хэрвээ тийм бололцоо байдаг бол мэтгэлцээнд мэтгэлцэх бололцоо олгож өгөөч ээ. Одоо ер нь ард түмний эсрэг үйлдэл болоод яваад өглөө.

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооныхон саяын холбогдох мэтгэлцээн зохион байгуулахтай холбоотой асуудлаар хууль зүйн холбогдох заалтыг нь олоод зохион байгуулах боломжтой эсэх талаар тайлбар өгөх хэрэгтэй байна. Дэгийн тухай хуулийн хэдийн хэддүгээр заалтаар аль үе шатанд мэтгэлцээнийг зохион байгуулах боломжтой эсэх асуудлаар. Раднаасэд гишүүн тийм санал

гаргасан, Өнөрболор гишүүн гаргасан, Чойжилсүрэн гишүүн бас гаргасан байгаа мэтгэлцээн зохион байгуулах. Тэгэхээр харин хэд дэх үе шатанд дээр нь тэрийг тодорхойлоод, байвал эшлээд тэргүүгээрээ бид нар бол тодорхой энэ асуудлыг хойшлуулаад мэтгэлцээнийг нь зохион байгуулж болж байна. Өнөөдрийн хурал дээр хийж болж байна.

39 дүгээр зүйл Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах гээд 39.1 дээр холбогдох Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нээлттэй болон хаалттай явуулж холбогдох санал, дүгнэлтийг гаргана.

Шаардлагатай гэж үзвэл Байнгын хороо төслийн тодорхой зүйл, хэсэг, заалтын талаар мэтгэлцээн явуулна. Шаардлагатай гэж үзвэл.

Хуралдаан даргалагч мэтгэлцээний хугацааг 60 минутаас илүүгүй байхаар тогтоох бөгөөд гишүүд саналаа чөлөөтэй илэрхийлэх боломж олгоно. Мэтгэлцээний хугацаа дуусмагц хуралдаан ердийн дэгээр үргэлжилнэ гэсэн байгаад байгаа юм байна.

Тэгээд мэтгэлцээн зохион байгуулах нь 39 дүгээр зүйлээрээ хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах гэдгээр бол байгаа юм байна. Тэгэхээр эцсийн хэлэлцүүлэг дээр байх уу. Тэгэхээр эцсийн хэлэлцүүлэг дээр бол байхгүй байна. Анхны хэлэлцүүлэг дээр бол байх юм байна гэсэн энэ Дэгийн тухай хуулийн заалт байна.

Тэгэхээр та мэтгэлцээн бол зохион байгуулж болохгүй нь байна. Одоо бол тодорхой санал нь түрүүний миний зааж өгсөн саналаар дүгнэлт гаргуулах эсэх талаар та бас горимын санал гаргаж болно.

Өнөрболор гишүүн.

**Д.Өнөрболор:** Тэмүүлэн гишүүн анхны хэлэлцүүлэг дээр тийм энэ



мэтгэлцэх энэ боломж нь нэгдүгээрт байсан. Энэ танай, манай энэ Байнгын хорооны энэ хуулийн улсууд бид нарт байна шүү дээ зөвлөмж өгөөд байж байх ёстой улсууд шүү дээ. Тэгэхэд миний гаргасан байж байгаа зарчмын зөрүүтэй санал болон миний гаргаж байгаа саналуудыг бүхэлд нь ерөөсөө бүүр ямар ч боломж байхгүй, огт боломж байхгүй гээд миний эрхийг хаачхаад дараа дараагийн миний эрхээр дамжуулаад сонгогчдын эрхийг хаачхаад, тэгээд дараа нь ингээд эцсийн хэлэлцүүлэг дээр ингэж бүүр ингэж авчирчхаад тэгээд намайг ингээд шахаад суугаад байгаа байхгүй юу бүгдээрээ. Би тэрэнд бол үнэхээр сэтгэл дундуур байна. Энэ миний асуудал биш биш. Энэ бол өнөөдөр сонгогчдын тэр дундаа бол бас энэ Улаанбаатар хотод амьдарч байгаа тэр байтугай юу гэдэг юм нийт Монгол Улсын иргэдийн Үндсэн хуулиараа эдлэх эрхтэй холбоотой ийм зөрчил үүсээд байгаа учраас л би энийг эцсээ хүртэл ингээд зүтгээд байгаа байхгүй юу. Үгүй энэ чинь эрүүл, аюулгүй орчинд амьдрах ёстой биз дээ. Энэ маш ойлгомжтой асуудал шүү дээ.

Тэгээд одоо ингээд би энэ энэ Тамгын газраар юу яах гэж байгаа юм байна. Одоо дэгээрээ тухайлах юм бол дэгээрээ Тамгын газраар дүгнэлт гаргуулна гээд тэгээд байгаа байхгүй юу. Тамгын газрын улсууд чинь орж ирэнгүүтээ та байна шүү дээ үүнийгээ ямар нэгэн, ядаж та нар энэ дагаж мөрдөх хуулиа боловсруулах энэ журмын энэ дагаж мөрдөх журмын хуулийг боловсруулах энэ агуулга дээрээ хуулиндаа өөрчлөлт оруулах агуулгыг оруулчихвал их зүгээр байгаад байна шүү дээ.

Тэгэхгүй бол тэгэхгүй бол та нар тэгээд улаан цагаан улаан цагаан Үндсэн хуулийг зөрчсөн, ард иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл байдал, энэ эрхэд халдсан сөрөг нөлөөлөл бүхий энэ хуулийг оруулж ирчхээд тэгээд анхны хэлэлцүүлэг дээр миний зарчмын санал, миний болон сонгогчдын эрхийг

хязгаарлачхаад тэгээд одоо эцсийн хэлэлцүүлэг учраас энэ мэтгэлцээн ч болохгүй, ийм ч юм болохгүй, тийм ч юм болохгүй одоо чи ингээд өнгөрсөн гээд.

Би өнгөрөх нь хамаагүй. Намар энэ чинь ард иргэдэд тэсрэлт болно шүү дээ. Та нар ойлгож байна уу. Ийм асуудал болно шүү дээ. Ийм асуудал болно. Энэ тэсрэхээс өөр аргагүй байдалд орно. Тэсрэхээс өөр аргагүй байдалд орно. Та нар өнөөдөр анхны хэлэлцүүлэг дээр намайг, миний эрхийг хааж боогдуулснаар өнөөдөр намайг ийм байдалд оруулж байна шүү дээ. Мэтгэлцмээр байна нэгдүгээрт. Нэгдүгээрт мэтгэлцмээр байна.

Хоёрдугаарт тэр дагаж мөрдөх журмын хуулийг боловсруулмаар байна. Энэ хууль Аж ахуйн нэгжийн орлогын татварт нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа энэ хуультай холбоотойгоор.

Гуравдугаарт энэ Байнгын хорооны дүгнэлт гаргуулмаар байна. Байнгын хорооны дүгнэлт гаргуулмаар байна. Хууль зүйн байнгын хорооны дүгнэлт гаргуулмаар байна.

**Г.Тэмүүлэн:** Өнөрболор гишүүн тодорхой санал гаргалаа. Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлаар сая өргөн баригдсан 2 хуулиуд, Үндсэн хууль болоод бусад хуулиудтай зөрчигдөж байгаа эсэх асуудлаар бол хууль зүйн 38.2-т заасны дагуу эрх зүйн дүгнэлт гаргуулах саналыг гаргаж байна гэж ойлголоо.

Тэгээд угаасаа Дэгийн тухай хуулиар 38.1-ээр Тамгын газарт албан бичгээр хүргүүлнэ. Тэгэхээр энэчээ бол дүгнэлт гаргуулах эсэх асуудлаар бол санал хураалт явагдана гэсэн үг болчхож байгаа юм. Таны саналын тухайд. Тэгээд өнөөдөр бол 3 дахь өдөр Төсвийн байнгын хорооны хуралдаан бас дахиад байгаа. Тэгэхээр тэр хурлаас өмнө буюу 2 хоногийн хугацаанд дүгнэлт гаргуулаад Төсвийн байнгын хороонд хүргүүлэх гэсэн чиглэлийг бас бид нар өгч болно. Хэрэв таны санал дэмжигдвэл гэсэн үг.

Хуулийн хугацаатай 2 хоногийн хугацаатай байгаа. 2 хоногоос тээ. 3 дахь өдөр тэгэхээр болно гэсэн үг болж байна.

Чойжилсүрэн гишүүн өөр санал байгаа юу. Саяын Өнөрболор гишүүнийхээр хураалгах хэрэгтэй байна. Өнөрболор гишүүнийхээр эхлээд саналаа хураалгачихъя тэгэх үү.

Тэгэхээр 38 дугаар зүйлийн эрх зүйн дүгнэлт хийж дүгнэлт гаргах буюу 38.2-т заасны дагуу тухайн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа эсэх хэрэв тухайн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцээгүй гэж эрх зүйн дүгнэлт гаргавал ямар хуулийн аль заалтад нийцэхгүй байгааг түүнчлэн тэдгээрийн үндэслэл тайлбарлалыг, үндэслэлийг тайлбарлах гэсэн ийм үндэслэлээр байгаа юм байна.

38.1 дээр нь холбогдох Байнгын хороо хэлэлцүүлгийн явцад хууль тогтоолын төслийн талаар эрх зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсэн бол гээд Тамгын газарт хүргүүлэхээр байгаа юм байна.

Ингээд энэ асуудлаар хууль зүйн дүгнэлт гаргуулъя гэдгээр бол бүгдээрээ санал хураалтыг явуулъя. Өнөрболор гишүүний гаргасан саналаар. Эрх зүйн дүгнэлт гаргуулах санал хураалтыг явуулъя. Дэмжье гэдгээр.

Өнөрболор гишүүний санал 85.7 хувиар дэмжигдлээ. Ингээд гаргасан саналын дагуу хууль, эрх зүйн дүгнэлт хийлгэх төсөл, төслийн тодорхой зүйл, заалт, хэсэг гишүүний гаргасан саналын томъёоллын талаар Тамгын газарт бичиг хүргүүлнэ.

Энэ саналын томъёолол дэмжигдсэн тул хэлэлцэх асуудлын дараалал хаа байна, тул Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Гаалийн тариф, гаалийн

татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараагийн Байнгын хорооны хуралдаан хүртэл буюу хууль, эрх зүйн, Тамгын газраас дүгнэлт ирэх хүртэлх хугацаанд бол энэ асуудлыг хэлэлцэхийг нь хойшлуулж байна.

Тэгээд нэг, хоёр, гуравдугаар асуудлууд гурвуулаа хамтдаа явж байгаа учраас гурван асуудлыг гурвууланг нь хойшлуулж байна.

Дээрээс нь нэмж бас би горимын санал бас гаргасан. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг бас хэлэлцэх зайлшгүй шаардлагатай байгаа. Засгийн газраас 6 сарын 27-нд өргөн баригдсан байгаа. Энэ асуудлыг ирэх 3 дахь өдрийн хуралдаанд хэлэлцэхээр байсан. Хууль санаачлагчдын зүгээс болоод Засгийн газрын зүгээс энэ асуудлыг бас энэ долоо хоног энэ 1 дэх өдрийн өнөөдрийн хуралдаанаар бас хэлэлцэж өгөөч гэсэн хүсэлтийг хэлсэн.

Тэгэхээр би гишүүнийхээ хувиар энэ асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлын дараалалд оруулъя. Нэгдүгээр асуудал болгож оруулъя гэсэн саналыг бас гаргаж байна.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Засгийн газраас өргөн баригдсан. Энэ асуудлыг гишүүдийг бас дэмжиж өгөхийг хүсье. Тэгээд хэлэлцэх асуудлын дараалал буюу нэгдүгээр асуудалд оруулах байгаа. Энэ асуудлаар санал хураалт явуулъя, дэмжье гэдгээр.

78.6 хувиар дэмжигдлээ. Ингээд гурав дахь асуудал нь Засгийн газраас өргөн баригдсан Төсвийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болж байна. Гурав дахь буюу одоогийн байдлаар гурав дахь эхний гурван асуудал батлагдсан учраас нэг дэх асуудал.

Хоёр дахь асуудал нь Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Гурав дахь нь Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн болон 30 гаруй гишүүдийн өргөн баригдсан хуулийн төслүүд гэсэн ийм 3 хэлэлцэх асуудалтайгаар хэлэлцэх асуудлыг ингээд баталж байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Эхний асуудал Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Чинзориг сайд яасан. Дараалал урагшлуулах тухай санал гаргах нь байна шүү дээ дахиад тээ. Булгантуяа гишүүн.

Чинзориг сайд байхгүй байгаа тул гурав дахь асуудлыг нэг дэх асуудал болгоё гэж байгаа юм байна.

**Х.Булгантуяа:** Байнгын хорооны даргаа Чинзориг сайд дараагийнхаа хурлаас ороод ирнэ. Тэгэхээр тэр болтол Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх санал хураалтыг явуулж өгөөч гэж хүсэж байна. Хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулж.

**Г.Тэмүүлэн:** Тэгвэл хэлэлцэх асуудалд гуравт байсан асуудлыг буюу Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэг дэх асуудал болгон хэлэлцье гэдэг саналыг гаргаж байна.

Хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулах саналыг дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Санал хураалт гишүүд анхааралтай байгаарай. Хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулах дэмжье гэдгээр.

Санал хураалт 71.4 хувиар дэмжигдлээ.

Ингээд хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулж нэг дэх асуудал нь Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

Хоёр дахь нь Засгийн газраас өргөн баригдсан Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

Гурав дахь нь Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гишүүдийн өргөн баригдсан хуулийн төсөл байна. Ингээд хэлэлцэх асуудалд орцгооё. Эхний асуудлыг хэлэлцэж эхэлье.

**Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Төсвийн байнгын хорооны 2022 оны 10 дугаар тогтоолоор уг хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажилласан.

Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа ахалж, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар Сандаг-Очир нар ажилласан болно. Ингээд хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна. Булгантуяа сайд.

**Х.Булгантуяа:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатараас 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны 2022 оны 12 оны 12 дугаар сарын 8-ны өдөр хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн байгаа.

Хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахалж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Ц.Сандаг-Очир нар орж ажилласан байгаа.

Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий дэд ажлын хэсгийг Сангийн яам, Татварын ерөнхий газар, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Худалдаа аж үйлдвэрийн танхим, “Татварын хөгжил, дэвшил холбоо” төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулсан бөгөөд ажлын хэсэг 2 удаа, ажлын дэд хэсэг 4 удаа хуралдсан.

Ажлын хэсэг хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 21, найруулгын 1 багц саналын томъёоллыг бэлтгэсэн бөгөөд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт заасны дагуу тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Нийт төсөлд татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг хувь хүн болон хуулийн этгээд эрхэлж болохоор байсныг хувь хүн зөвлөх үйлчилгээг бие даан гүйцэтгэнэ. Үйлчилгээний чанар, харцуцлагад сөргөөр нөлөөлөх, хувь хүний үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлоход хүндрэл бэрхшээл үүсэхээр байгааг харгалзан зөвхөн хуулийн этгээд татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг эрхлэхээр өөрчилж, харин зөвлөх үйлчилгээ эрхлэхдээ бусад татварын мэргэшсэн зөвлөхтэй

гэрээгээр хамтарч ажиллах нь нээлттэй байхаар.

Хоёрт, Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн татвар хариуцсан ажилтан татварын мэргэшсэн зөвлөх байх.

Гуравт, Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь даатгалын байгууллагаа өөрөө сонгож мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах.

Дөрөвт, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийг үүсгэн байгуулахад 3, салбар нээхэд орон тооны 2 мэргэшсэн зөвлөхтэй байх. Одоо үйлчилж байгаа тооны шаардлагыг бууруулж, эрдэм шинжилгээ, сургалтын чиглэлээс өөр ажилд давхар эрхэлдэггүй 2-оос доошгүй орон тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх. Салбарын хувьд орон тооны 1 мэргэшсэн зөвлөхтэй байх.

Тавд, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийн 5 жилийн хугацаагаар олгож мөн хугацаагаар сунгахаар зааж, харин татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгохтой ижил төстэй байгууллагын жишиг, олон улсын сайн туршлагыг харгалзан 3 түвшний зэрэглэлтэй буюу 1, 2 дугаар түвшний эрхийг тав, тав, таван жилийн хугацаагаар 3 дугаар түвшний зэрэглэлийг хугацаагүй олгохоор.

Зургаад, Татварын мэргэшсэн зөвлөхийн хүрээг нэмэгдүүлэх зорилгоор татвар, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 5-аас доошгүй жил их, дээд сургуульд багшилсан багш, 4-өөс доошгүй жил татварын асуудал эрхэлсэн төрийн байгууллагад ажилласан албан хаагчийг хамруулахаар.

Долоод, Татварын улсын байцаагчийн ажил албан тушаалд 10-аас дээш жил ажилласан бол татварын эрх

олгох шалгалтын, татварын, хууль эрх зүйн болон татварын онол, ёс зүйн гэх 2 төрлийн шалгалтаас чөлөөлөгдөхөөр.

Найд, Мэргэшсэн зөвлөхүүдийн хариуцлага ёс зүйн асуудлыг чангатгах, хуульчлах нь зүйтэй гэж үзэж, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаал, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завиших болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн хувь хүний орлогын албан татварын тайланг хуульд заасан хугацаанд тайлагнаагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

9.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн орон тооны татварын мэргэшсэн зөвлөх ёс зүйн зөрчлийг гаргасан талаарх Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолт болон бусад этгээдээс мэдээлэл ирсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох, эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэхээр.

Аравт, Татварын мэргэшсэн зөвлөх нь зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд харьяалагдахгүйгээр ганцаарчлан татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэхгүй байхаар.

Арван нэгт, Татварын мэргэшсэн зөвлөхийн чиг үүрэгт татварын хууль тогтоомж, түүний өөрчлөлт, татвар төлөгчийг татварын эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар татвар төлөгчид мэдээлэл, зөвлөгөө өгөхийг үүрэг болгох зэрэг агуулга бүхий зарчмын зөрүүтэй саналуудыг бэлтгэлээ.

Ажлын дэд хэсгийн зарим гишүүдийн зүгээс татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн засаглал, үйл ажиллагаа, санхүүгийн ил тод байдлыг сайжруулах, татварын тогтолцоонд нийгэмлэгийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхой тусгах чиглэлээр гаргасан саналыг Монгол Улсын Их

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт заасан хуулийн төслийг хэлэлцэх санал гаргах үүрэг, хүрээ хязгаарт нийцүүлэн хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тусгагдаагүй зүйл, хэсэг, заалтад өөрчлөлт оруулахгүй байх зарчмыг баримтлан санал бэлтгээгүй болно.

Мөн “Татварын хөгжил, дэвшил холбоо” төрийн бус байгууллагаас хуулийн хэрэгжилтэд бүхэлд нь үнэлгээ хийсний дараа шинэчилсэн найруулга хэлбэрээр өргөн мэдүүлж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж санал гаргасныг хууль санаачлагчдын бүрэн эрхэд халдахаар байна гэж үзэж өргөн мэдүүлсэн төслийн хүрээнд ажлын хэсэг ажиллалаа.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг та бүхэнд тараасан болно.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсгийн дарга Булгантуяа сайдад баярлалаа.

Ингээд хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэхээр байгаад байгаа. Тухайн зүйлтэй холбогдуулж хууль санаачлагч болоод ажлын хэсэг бусад оролцогчдоос асуулт асууж болно.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилсэн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулж эхэлье.

Хуулийн төслийн I дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Даваасүрэн гишүүн байна. Даваасүрэн гишүүнээр тасалъя. Даваасүрэн гишүүн

асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргая.

**Ц.Даваасүрэн:** Та бүхний энэ өглөөний амгаланг эрье. Энэ хуулийг би өөрөө санаачилж батлуулсан хууль байгаа юм. Тэгээд энэ хуулийг гол ач холбогдол бол энэ аж ахуй эрхэлж байгаа улсуудад маш чухал хууль. Татварын гол зөвлөгөө өгдөг, татварын тайланг нь гаргаж өгдөг, мөн татвар бас шударга, зөв байхад бас нөлөөлдөг ийм тогтолцоо. Бид нар бол энийг Япон, Солонгосоос нэлээн хуулбарлаж ингээж хийсэн тогтолцоо байгаа юм.

Тэгээд сүүлд бас 13 онд байна уу Тэмүүжин сайд байхдаа хууль санаачилж оруулж ирээд зарим эрх, үүргийг нь хязгаарлачихсан юм. Тэгээд одоо энэ манай энэ ажлын хэсэгт орж ирсэн улсууд сайн мэдэж байна уу, үгүй юү. Тэр буцааж сэргээж чадсан уу тэр заалтуудыг энэ хуулиараа. Танай Татварын мэргэшсэний энэ нягтлан бодох холбооны тэргүүн чинь өөр хүн байсан. Тэр нь оролцоогүй юм уу, нэг эмэгтэй байсан. Тэр дордуулчихсан заалтууд оруулчихсан байхгүй юу Тэмүүжин сайд. Тэрийг өөрчилсөн үү, яагаад.

**Г.Тэмүүлэн:** Даваасүрэн гишүүний асуултад ажлын хэсэг хариулъя. Дэд ажлын хэсэг. Ажлын хэсгийн микрофоныг өгье.

**Ү.Галмандах:** Сайн байцаана уу. Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн Галмандах байна. Манай нийгэмлэгийн ерөнхийлөгч Алтанзаяа багш маань одоо энэ 10 цагаас төрийн одон, гавьяатыг гардаж авахаар тийм ажилтай байгаа учраас энэ хуралд оролцож чадаагүй байгаа.

13 онд тэр Тэмүүжин тухайн үед Хууль зүйн сайд байсан хүн. Тэмүүжин сайдын хувьд оруулсан зүйл нь бол эрх зүй, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний компанид эрх зүйч, татвар хариуцсан эрх зүйчтэй байна гэдэг тэр

зохицуулалтыг нь бол энэнд байх шаардлагагүй гээд ингээд аваад авчихсан байгаа. Тэгээд тэрнээс хойш бол нэмж оруулаагүй байгаа. Эрх зүйч гэдэг зохицуулалтаараа бол оруулаагүй. Тийм, гишүүний өргөн мэдүүлсэн нэмэлт, өөрчлөлтөөр өргөн мэдүүлсэн төслийн хүрээнд бас энийг бас өргөн бариагүй.

**Г.Тэмүүлэн:** Даваасүрэн гишүүн нэмж тодруулъя.

**Ц.Даваасүрэн:** Тэгээд тухайн үедээ бол энэ ёстой болохгүй гээд л та хэд чинь нэлээн асуудал болгоод л тэгээд л би бас Байнгын хороо, чуулганы хуралдаан дээр бас эсэргүүцээд тэгээд л дийлээгүй л дээ. Тэгээд одоо яагаад та нар тэгээд энийгээ хүлээн зөвшөөрөөд суучхав. Уг нь бол сая ингээд нэгэнт ингээд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа юм чинь та нар энийгээ оруулаад явчихсан бол. Одоо бид нар наадхыг чинь санаачилж, өөрчилж болохгүй. Яагаад гэвэл энэ нэмэлт, өөрчлөлт учраас хөндөөгүй асуудлыг бид нар хөндөж чадахгүй.

Уг нь нэг мөр л хиймээр байгаа юм л даа энэ хуулиудыг. Тэгээд тэр агуулга нь уг нь байх ёстой зүйл байсан юм. Тэгээд тухайн үед нь л нэг хууль оруулж ирэхдээ дагаж өргөн бариад ингээд аваад хаячихсан байхгүй юу.

**Г.Тэмүүлэн:** Нэмж хэлэх тайлбар байна уу ажлын хэсэг. Байхгүй юу. За ойлголоо. Тэгвэл нэмэлт тайлбар байхгүй байна. Ажлын хэсгээс 1 дүгээр зүйл заалттай холбогдуулж 9 зарчмын зөрүүтэй саналыг гаргасан байна.

Эхний саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

4.3.Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн татвар

хариуцсан ажилтан татварын мэргэшсэн зөвлөх байна.

4.4 нь татварын мэргэшсэн зөвлөх нь зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд харьяалагдахгүйгээр ганцаарчлан татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэхгүй гэсэн байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа, Ганбаатар, Сандаг-Очир цаашид ажлын хэсэг.

Энэ саналтай холбогдуулж Батжаргал гишүүн. Батжаргал гишүүн микрофоныг өгье. Асуулт асуух юм байна.

**Ж.Батжаргал:** Үгүй үгүй энэ чинь санаа нь яг мөн. Гэхдээ томъёолол нь арай л марзан юм. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь харьяалагдахгүйгээр ганцаарчлан татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэхгүй гэж. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг зөвхөн татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд үзүүлнэ л гэж л явах ёстой. 4.4 дээр тийм л юм байгаад байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Саяын 4.3 болоод 4.4-тэй холбоотой. Ажлын хэсэг тайлбар хэлэх үү томъёолол дээр. Эсвэл гишүүд зарчмын зөрүүтэй санал бас гаргаж болно. Томъёолол дээр, энэ томъёолол дээр. Булгантуяа сайд.

Булгантуяа сайдад микрофон өгье. Даваасүрэн гишүүн нэмж тодруулах зүйл байна тээ. Даваасүрэн гишүүн.

**Ц.Даваасүрэн:** Манай энэ ажлын хэсгийн гишүүд нэг юм анхаараач. Энэ төрийн болон төрийн өмчийн оролцоотой этгээдүүдийг заавал татварын мэргэжсэн зөвлөх байна гэж ингэж хэлэх шаардлага байна уу. Энэ чинь бас л томилгоо дээр тэгээд л нөгөө энэ чинь АТГ-ээс бичиг авдаг байх. Ингээд л бас нэг л шалтаг, үндэслэл болж эхлэх байхгүй юу. Тэгээд давхар давхар дөнгө зүүсэн л ийм юмыг л хуульд

хийгээд байдгаас болж энэ төрийн хүнд суртал, чирэгдэл гэдэг юм чинь бий болж байгаа шүү дээ. Тэгээд ахиад нэг төрийн хүнд суртал, чирэгдэл байхгүй юу энэ чинь.

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсэгт тайлбар өгөх үү. Дэд ажлын хэсэг хариулах уу, Булгантуяа сайд хариулах уу. Саяын Даваасүрэн гишүүн болон Батжаргал гишүүний хэлсэн 2 асуудал дээр 4.3, 4.4 дээр Булгантуяа сайд.

**Х.Булгантуяа:** Бид нар бас энэ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль гээд эдгээр хуулиуд дээр ялангуяа төрийн болон төрийн өмчийн үр оролцоотой, дээрээс нь нэмээд олон нийтэд хувьцаагаа гаргасан аж ахуйн нэгжүүд энэ тэрд ажиллаж байгаа энэ нарийн мэргэжлийн хүмүүс бол нэлээн хариуцлагатай ажил, албан тушаалтнууд учраас нарийн мэргэжлийн хүмүүс ер нь байх нь зүйтэй гэж бас үзээд байгаа юм.

Энэ Төрийн болон төрийн өмчийн ололцоотой хуулийн этгээдийн тухай хууль бас тун удахгүй орж ирэх байх. Одоо улсын хэмжээнд бас ялангуяа ийм компаниудын хувьд бол санхүү хариуцсан хүмүүс, татвар хариуцсан хүмүүс нарийн мэргэжлийн хүмүүс байж энэ компаниудын татвар, санхүүгийн асуудал илүү хариуцлагажих нь бас зүйтэй юм л гэдэг бас ийм байр суурийг бариад байгаа юм.

Ер нь бол одоо ч гэсэндээ бид нар бас тодорхой хэмжээний юунууд тавьдаг юм шүү дээ. Мэргэшсэн нягтлан бодох байх энэ тэр гээд төрийн байгууллагууд энэ тэр дээр. Тэгэхээр татварын татвар хариуцсан хүн бол татварын мэргэшсэн зөвлөх байхад бол энэ.../минут дуусав./

**Г.Тэмүүлэн:** Нэмж тайлбарлах уу. Даваасүрэн гишүүн нэмж тодруулъя. Даваасүрэн гишүүн.

**Ц.Даваасүрэн:** Ер нь бол энэ компанийн тухай хуулиудаараа зохицуулагдаж байгаа юм бол ерөнхий нягтлан нь мэргэжсэн нягтлан байна гээд хийчихсэн л байгаа байхгүй юу. Тэгээд мэргэжсэн нягтлан байгаа тохиолдолд заавал ингээд л дараа дараагийнх нь тийм байна гээд л ингээд байдаг чинь ер нь буруу шүү. Тэгээд мэргэжлийн байгууллага бүр ингээд өөртөө сургалт явуулах, мөнгө олох маягаар ингэж хандаад байж болохгүй шүү дээ. Би яах вэ өмнө нь бас энэ хуулийг санаачилж байсан хүний хувьд бол би дэмий байх гэж ингэж бодож байна. Тухайн үед ч бас яригдаж л байсан юм. Зүгээр л сургалт явуулах, мөнгө олох арга хэрэгсэл байхгүй юу. Тэгээд энэ чинь эргээд нөгөө компаниа, тэгээд дараагийн дараагийн томилгоонууд дээр гай болдог.

Ер нь бол мэргэжсэн нягтлан байх тухай асуудлыг бол компаниуд нь тавиад явчхаж байгаа хууль дээрээ байгаа учраас тэр мэргэжсэн нягтлангаараа л явсан нь дээр гэж бодож байна.

**Г.Тэмүүлэн:** Санал хураалт явуулах нь байна. Ажлын хэсэг нь, дэд ажлын хэсэг нь энэ дээр тайлбар өгөх үү. 4.4 бол болохгүй байх гээд байна угаасаа тээ. Даваасүрэн гишүүн бол 4.3-ыг дэмжихгүй, хасах ёстой гэсэн томъёолол гэж.

5 дугаар номер ажлын дэд хэсэг тайлбар өгье 2 асуудал дээр.

**Б.Болормаа:** Би Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Болормаа байна. Ажлын хэсгийн гишүүн.

4.3 дугаар заалт дээр Сангийн яам бол эсрэг байр суурьтай байсан. Энийг хасах гэдгээр яаман дээр бид нар ажлын, яамны хүрээнд энийг хасах гэдэг байр суурьтай байгаа. Татварын мэргэжсэн зөвлөх заавал байхыг хуульд хуульчлах шаардлагагүй гэж үзсэн байгаа.

4.4 дээр татварын мэргэжсэн зөвлөхийн үйлчилгээг зөвхөн хуулийн этгээд гүйцэтгэнэ гэсэн ийм л агуулгатай өгүүлбэр байхад болно. Тийм хуулийн этгээдээр гүйцэтгэнэ л гэсэн үг.

**Г.Тэмүүлэн:** Ганбаатар гишүүн ажлын хэсгийн гишүүн бас нэмж тайлбар өгье гэж байна уу тээ. Тайлбар.

**С.Ганбаатар:** Энэ 4.3 байвал их зүгээр байгаа юм. Яагаад гэвэл миний ойлгосноор төрийн өмчит компаниуд, төрийн болон төрийн өмчит компанийн 100-аадхан л аж ахуйн нэгж байгаа. Хэдэн их наядын татварын болон зөрчил, одоо би энэ аудитын тухай асуудал оруулж ирэх гээд байж байна. Одоо энэ аудит дээр л гэхэд чинь л зүгээр л хөрөнгийн алдаа гэхэд хэдэн их наядаараа, тэдэн тэрбумаараа байгаа. Тэгээд энэ дээр энэ татварын асуудал дээр төр л юм хойно стандартаа тавиагч. Яг төрийн өмчийн компанийн болон төрийн энэ үйл ажиллагаа явуулж байгаа энэ өмчтэй харьцаж байгаа улсууд татварын мэргэжсэн бай энэ дээр шинэ орон тоо ерөөсөө гаргах гээгүй шүү дээ. Энэ чиглэлээр татварын талаар ажиллаж байгаа хүмүүс нь стандартаа, мэдлэгээ нэмэгдүүлээч л гэдэг шаардлага тавьж байгаа. Сүүлд нь энэ чинь би татварын талаар мэдээгүй байсан шүү дээ, мэдлэггүй байсан шүү дээ гэдэг хэлэх ямар ч эрхгүй. Төр бол стандартаа л тавьж байгаа. Шинээр орон тоо байхгүй. Энэ дээр хуулийн этгээд.../минут дуусав./

**Г.Тэмүүлэн:** Минутыг нь нэмж өгье Ганбаатар гишүүнд.

**С.Ганбаатар:** Хар даа энэ дээр төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн татвар хариуцсан ажилтан нь гэж байгаа юм. Хэрвээ ажилтан байгаа бол гэж байгаа юм. Шинээр бид орон тоо нэмэх юм уу, ямар нэгэн санхүүгийн хүндрэл учруулаагүй. Татвар хариуцсан ажилтан байгаа бол тэр нь татварын мэргэжсэн зөвлөх байна л гэж байгаа юм. Би ийм



ажлын хэсэгт ажилласан учраас татварын чиглэлээр Монголын төр л байгаа бол татвараа сайн авах, ядаж энэ төрийн өмчит компаниудаас татвараа сайн авах. Төрийн өмчийн компаниуд одоо миний сонссоноор 16.4 их наядын алдагдалтай ажиллаж байгаа шүү дээ. Тэр чинь бүүр татвараас зугтааж байгаатай адилхан. Энэ дээр хариуцлагыг нь чангатгая, хариуцлагыг нь чангатгахдаа хариуцлага тооцъё гэсэнгүй. Мэдлэгтэй бай, мэргэшсэн бай л гэж хэлж байгаа юм.

Ингээд энэ санааг бол ажлын хэсэгт байгаа гишүүдийн хувьд бид дэмжиж байгаа. Та бүхэн маань дэмжиж өгөөрэй.

**Г.Тэмүүлэн:** Даваасүрэн гишүүн санал, зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан байна.

Хуулийн төслийн 4.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг бол ирүүлсэн байна. Энэ саналаар саналаа тайлбарлах уу. Даваасүрэн гишүүн саналаа тайлбарлаж байна.

Даваасүрэн гишүүний микрофоныг өгье.

**Ц.Даваасүрэн:** Тэгэхээр татварын асуудал хариуцсан ажилтан гэж байгаа чинь өөрөө ерөнхий нягтлан болчхож байгаа байхгүй юу. Компанийн татвар, тайлан, санхүүгийн асуудлыг ерөнхий нягтлан хариуцаж байгаа юм.

Ерөнхий нягтлан дээр тавигдаж байгаа шаардлага нь өөрөө мэргэжсэн нягтлан байна гэж байгаа юм. Тэр зөв байхгүй юу мэргэжсэн нягтлан байна. Мэргэжсэн нягтлангийн сургалтад татварын асуудлууд энэ тэр бүх л юм байгаа байхгүй юу. Тийм учраас дахиад л тэнд сургана, энд сургана гээд ингээд тийм сургалт хөөсөн байдал бол энэ төрийн бус байгууллагуудын бас гол орлого л болчхоод байгаа юм л даа. Тэгээд тэрүүгээрээ ингээд төрийн ажилд бас тийм чөдөр, дөнгө байлгаж бас юу

болохгүй гэдэг агуулгаар энэ саналыг гаргаж байгаа шүү.

Тэртээ тэрэнгүй татварын асуудал эрхэлж байгаа ерөнхий нягтлан бол мэргэшсэн нягтлан байгаа.

**Г.Тэмүүлэн:** Даваасүрэн гишүүний саналаар санал хураалтыг явуулъя.

Хуулийн төслийн 4.3 дахь заалтыг хасах. Санал хураалт дэмжье гэдгээр санал хураах нь байна. Гишүүд анхааралтай байгаарай.

Даваасүрэн гишүүний санал дэмжигдсэнгүй. Одоо тэгэхээр ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч яах гэж байна. Саналын томьёолол гаргах уу та. Ажлын хэсгийн ахлагч хувь гишүүний үүднээс. Булгантуяа гишүүний саналыг сонсьё. Саналаа гаргая.

**Х.Булгантуяа:** Энэ хууль бас гарсныхаа дараагаар бид нар бас эхэн үедээ бол зах зээлийг жоохон чөлөөтэй тавьж өгөөд, дараа нь бид нар бас жоохон зохицуулалтуудыг хийж байх ёстой гэсэн утгаараа энэ хууль дээр бас ингэж оруулж өгсөн юм шүү гишүүд ээ.

Дараачийнх нь энэ томьёоллын хувьд жоохон Батжаргал гишүүний хэлж байгаа бас үнэн. Тэгвэл татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг, үйлчилгээг хуулийн этгээд, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний хуулийн этгээд эрхэлнэ гэж оруулж өгвөл найруулга зүйн хувьд болж байна уу. Ийм байдлаар тэгвэл санал хураалгая тэгэх үү. Тэгээд яах вэ, энэ бол зүгээр хуулийн энэ зөвлөх үйлчилгээг хуулийн этгээдээр үзүүлэх нь хариуцлагын хувьд зүйтэй юм. Тэгээд мэргэжлийн даатгалд хамрагдах ёстой гэдэг ийм зарчмыг манай ажлын хэсэг баримталсан юм.

**Г.Тэмүүлэн:** Булгантуяа гишүүний гаргасан саналаар санал хураалтыг явуулъя. Дэмжье гэдгээр. Санал хураалт, гишүүд анхааралтай байгаарай.

Санал 58.3 хувиар дэмжигдсэн байна. Булгантуяа гишүүний гаргасан санал.

Булгантуяа гишүүний санал дэмжигдээд, Даваасүрэн гишүүний санал унасантай холбогдуулаад ажлын хэсгийн саналыг нь уншиж танилцуулъя.

4.3.Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн татвар хариуцсан ажилтан нь татварын мэргэшсэн зөвлөх байна гээд өөрчлөн найруулах гэсэн ийм санал байна. Санал хураалт.

41.7 хувиар дэмжигдсэнгүй. Энэ 4.3 дахь санал унасан гэсэн үг. Хуулийн төслийнх нь санал хэвээр үлдэж байна гэсэн үг болчхож байгаа юм. Санал 41.7 хувиар дэмжигдсэнгүй.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

6.1.7.татварын тайлангийн нийцлийг хянах, шинжилгээ хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 10.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

10.1.9.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

58.3 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 11.2, 11.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11.2.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн гишүүн байх бөгөөд татвар төлөгчийг татварын эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар татвар төлөгчдөд мэдээлэл өгөх үүрэгтэй.

11.3.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь даатгалын байгууллагаа өөрөө сонгож, мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулна. Санал гаргасан ажлын хэсэг.

Батжаргал гишүүн саналтай байна. Батжаргал гишүүний микрофоныг өгье.

**Ж.Батжаргал:** Найруулгын л юм байгаад байна. 11.2-оо уншаарай. Мэдээлэх үүрэгтэй байх юм уу, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй байх юм уу.

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсэг асуултад хариулах уу. Хэн хариулах вэ. Гараа өргөөрэй. 5 номер, 6 номер.

**Ү.Галмандах:** 11.2 дээр энэ мэдээлэл гэдгээр явж байгаа. Яагаад гэвэл татварын зөвлөх үйлчилгээний компанид үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгч нь үйлчлүүлэгч гэдгээр явна. Тэгэх юм бол эд нарын татварын зөвлөх үйлчилгээгээ үзүүлээд явна.

Ер нь нийт татвар төлөгчдөд бол татварын урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгөх ёстой гэдэг байдлаар энэ Сангийн яам маань оруулж ирсэн ийм санал байгаа юм. Илүү хариуцлагажуулж өгч байна л гэсэн үг.

**Г.Тэмүүлэн:** Өөр асуулттай гишүүд байна уу. Алга байна. Санал хураалтаа явуулъя.

75 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 12.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

12.1.8.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, орон тооны татварын мэргэшсэн зөвлөх нь ёс зүйн зөрчилгүй талаарх Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолт.

Даваасүрэн гишүүн асуулт асууя.

**Ц.Даваасүрэн:** Энэ бас жоохон төвөгтэй асуудал. Тэгэхдээ гишүүд бас жоохон нэгнийхээ хэлж байгаа юмыг бид нар чинь бас төрд ажиллачихсан учраас цаанаа юу болдгийг нь мэдээд хэлээд байгаа шүү дээ. Тэгээд одоо жишээлбэл энэ дээр бас татварын талаарх тодорхойлолт авна гэж байгаа юм. Бид нар татвар төлсөн, төлөөгүй гэдэг талаар байнгын л тодорхойлолт, тэр битгий хэл улс төрийн албан тушаалтан сонгуульд оролцохдоо хүртэл авдаг. Тэгээд ийм баахан тодорхойлолтууд, тийм баахан ийм газрын бичгүүд гээд ингээд 1 амаараа болохоор ингээд л хүнд сурталгүй байна гээд л ингээд олон юм ярьцаана.

Нөгөөдхөөрөө ингээд хуулиараа нэмээд байна. Ингээд морь унасан толгойгүй хүн шиг Улсын Их Хурлын гишүүн хүн байж байж. Тэгээд энэ хууль дээр байгаа бол энийг нь авч хая л даа. Тэгээд та нар ингээд янз бүрийн юм ингээд нэмээд байх юм бол төрийн бус байгууллагуудад янз бүрийн байдлаар үйлчилгээ эрхлэх, мөнгө олох энэ арга замыг нээх гэж ингэж хууль санаачилж байгаа бол буруу шүү. Тэгээд бүгд эрх мэдэл авах гэж ингэж гүйлдэнэ. Тэгээд энэ нь дараа нь хуулийн бөөн зөрчил болно.

Ер нь сүүлийн үед гарсан хуулиуд маш муу гарч байгаа шүү. Одоо энэ Зөрчлийн хууль гээд балай юм хийгээд хаячихсан. Нөгөө хууль дээр нь тэр байгууллага олгоно гэж байхад өөр байгууллага олгоно гээд гаргачихсан

Зөрчлийн хууль дээрээ. Өнөөдрийн манай байгаа парламентын байдал тэр.

Яг тэрэнтэй ижилхэн одоо ингээд л тэр тэрнээс тодорхойлолт дахиад татвараас тодорхойлолт авахаас гадна эднийхээс тодорхойлолт авна. Тэгээд ийм юм хийгээд байгааг чинь нийгэм бид нарыг энэ Их Хурлыг шүүмжлээд байгаа шүү дээ. Тэгээд орж ирчхэнгүүтээ тэгээд бас, би 4 жил эхлээд орж ирэхдээ бас бусдыгаа сонсдог л байсан. Ялангуяа олон жил сууснуудыгаа сонсдог л байсан. Ерөөсөө тэгж сонсож байгаа ч юм байхгүй. Харин ч бараг эсрэгээр даръя гэсэн агуулгатай хандаж байгаа байхгүй юу. Бид нар энэ ажил, амьдралыг чинь мэддэг болоод л хэлж байгаа шүү дээ та нарт. Тэгээд өөрсдөө л мэд. Ингээд дүнг нэмээд байх юм бол нэмээд л бай.

**Г.Тэмүүлэн:** Санал хураалт 33.3 хувиар ажлын хэсгийн санал дэмжигдсэнгүй.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 12.1.9, 10 дахь заалтын 18.2.9 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 14.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14.7.Татварын улсын байцаагчийн ажил, албан тушаалд 10-аас дээш жил ажилласан бол татварын албаны тодорхойлолтыг үндэслэн энэ хуулийн 15.1.3-т заасан хоёроос дээшгүй шалгалтаас чөлөөлж болох бөгөөд уг харилцааг татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох, сунгах журмаар зохицуулна гэсэн байна. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдсэн байна.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 16.1.7, 9 дэх заалтын 17.1.6

дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

16.1.7. татварын хууль тогтоомж, түүний өөрчлөлт, татвар төлөгчийг татварын эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар татвар төлөгчдөд сурталчлан таниулах, мэдээлэл өгөх.

17.1.6. Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаал, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завиших болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлсэн, хувь хүний орлогын албан татварын тайланг хуульд заасан хугацаанд гаргаагүй. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

75 хувиар дэмжигдлээ.

9. Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 18.2.10 дахь заалтын “шаардлагын хэм хэмжээг” гэснийг “шаардлагын холбогдох журмыг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

75 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс 1 саналтай байна.

Төслийн 2 дугаар зүйлийн 11.1.5 дахь заалтыг агуулгын хувьд нийцүүлэн, төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт руу шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11.1.5. тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан, эцсийн өмчлөгч өөрчлөгдсөн болон энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан мэдээлэл өөрчлөгдсөн бол энэ тухайгаа Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр

мэдэгдэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

75 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс 3 дугаар зүйлтэй холбогдуулан 3 санал, 4 санал байх шиг байна. Эхнийхийг нь уншиж танилцуулъя. 6 санал байна. Эхнийхийг нь уншиж танилцуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3.1.3. “зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд” гэж татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөлийг. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

12. Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын гарчиг болон 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**9 дүгээр зүйл. Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд**

9.1. Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.3-т заасан хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах бөгөөд зөвлөх үйлчилгээ эрхлэхдээ бусад татварын мэргэшсэн зөвлөхтэй гэрээгээр хамтарч ажиллаж болно. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

13. Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 10.1.1, 10.1.2, 10.1.8 дахь

заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

10.1.1.эцсийн өмчлөгч нь татварын мэргэшсэн зөвлөх байх;

10.1.2.эрдэм шинжилгээ, сургалтын чиглэлээс өөр ажил давхар эрхэлдэггүй 2-оос доошгүй орон тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх;

10.1.8.хуулийн этгээд салбартай бол түүнд нэгээс доошгүй орон тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх. Санал гаргасан ажлын хэсэг.

Даваасүрэн гишүүн асуулт асууя.

**Ц.Даваасүрэн:** Энэ дээр ингээд бас мэргэшсэн зөвлөхтэй бай мэргэшсэн зөвлөхтэй бай гэж байгаа юм. Энэ чинь аль байгууллагын хувьд хэлээд байгаа билээ. Энийг тодруулъя даа. Сайн энийгээ тодруулж авахгүй бол ингээд л бүгдийг нь мэргэшсэн зөвлөхтэй бай гээд л. Тэгээд сургана гээд л. Энийг яг төрийн бус байгууллагуудын ийм амбиц байгаа байхгүй юу мөнгө олдог. Тэрийг нь бас жоохон хянаж, хязгаарлах нь бид нар л зохицуулж, хуулиар зохицуулж өгөхгүй бол бас болохгүй шүү дээ.

Тэгэхээр яг энэ ямар байгууллагуудыг ингээд хуулийн этгээд бүүр салбартай байвал мэргэжсэн зөвлөхтэй бай гэх юм уу.

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсгийн асуултад хариулъя. Булгантуяа гишүүн.

**Х.Булгантуяа:** Энэ нөгөө татварын мэргэшсэн зөвлөгөө үзүүлдэг хуулийн этгээдийг яриад байгаа юм. Тэгэхээр татварын мэргэшсэн зөвлөгөө үзүүлдэг хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч нь татварын мэргэшсэн зөвлөх байх.

Дээрээс нь нэмээд 2-оос доошгүй орон тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх. Одоо 3 байгаа. Тэр нь

бас жоохон хэцүү. Салбарт тийм олон бас татварын мэргэшсэн зөвлөх бас байхгүй байгаад байна гээд байгаа юм.

Гэхдээ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Аудитын тухай хууль гээд энэ бусад хуулиудад 2-оос доошгүй гэж байгаа. Тэгэхээрээ үүнтэй нийцүүлж оруулсан байж байгаа. Тэгээд салбартаа бол түүнд 1-ээс доошгүй орон тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх гэж оруулж өгч байгаа.

Тэгэхээр эд энэ үйлчилгээг жишээлбэл нягтлан, санхүүгээр өөрснөө ийм алба ажил, албан тушаалтан байхгүй компаниуд татварын зөвлөгөө авдаг энэ тэр байх учраас нарийн мэргэжлийн хүмүүс бас байх нь зүйтэй юм гэж бас бид нар ажлын хэсгээс үзэж, оруулж өгсөн байж байгаа. Тийм, компанийн хувьд байхгүй юу. Тийм.

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

**Ж.Батжаргал:** Тийм. Ерөөсөө татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг эрхлэх хуулийн этгээдийг үүсгэн байгуулагч нь буюу тэр эцсийн өмчлөгч нь татварын мэргэшсэн байх юм байна. Би тэгж ойлгосон. Үгүй ер нь хэдүүлээ үнэхээрийн л аудиторлох гээд байгаа бол мэргэшсэн татварын зөвлөхгүйгээр татварын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг юм гэж байхгүй шүү. Салбар 1-ээс доошгүй энэ тэр гэсэн үг байхгүй шүү дээ.

Хэрвээ тэр салбартай бол тэр салбараар үйлчлүүлж байгаа компанид яг тэр татварын зөвлөх үйлчилгээгээрээ мэргэшсэн тэр л мэргэжилтэн нь зөвлөгөө үзүүлэх ёстой. Тэр нь баталгаажих ёстой. Өнөөдөр биднүүс энэ аудитын компаниудыг тэгж л эрх зүйн зохицуулалт юуг нь тодорхой болгосон биз дээ. Яг л тэрүүгээрээ л явахгүй бол болохгүй шүү дээ.

Тэгэхээр 1-ээс доошгүй энэ тэр гэдэг үг илүүдээд байгаа байхгүй юу. Яг үнэнийг хэлэхэд. Тэр татварын

мэргэшсэн зөвлөх л тийм үйлчилгээ үзүүлнэ. Өөр хүн үзүүлэх боломжгүй.

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсгийн дарга Булгантуяа гишүүн, сайд.

**Х.Булгантуяа:** Батжаргал гишүүний хэлж байгаа үнэн. Энэ хууль бас үйлчлүүлэгчдийн эрх ашгийг бид нар хамгаалах ёстой. Яагаад гэвэл төр бүхэл бүтэн хууль гаргаад, тусгай зөвшөөрөл өгөөд, төрийн үйлчлүүлэгч та бүхэнд татварын мэргэжлийн зөвлөгөө үзүүлж чаддаг ийм хуулийн этгээд эдгээр нь байна гээд ингээд ажиллуулж байгаа учраас энд бол мэргэжлийн хүмүүс л ажиллах ёстой.

Тийм учраас бид нар 2-оос доошгүй орон тоотой байх ёстой гэж үзсэн. Яах вэ салбар зөвлөлтэй байгаад тухайн салбар зөвлөлд нь бас жишээлбэл оффис менежер ч гэдэг юм уу, нарийн бичиг ч гэдэг юм уу тийм албан тушаалтнууд бас байж болно.

Гэхдээ салбар зөвлөл байгуулахын тулд тэр салбарын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд авч явахын тулд жишээлбэл аймаг, орон нутагт салбартай байж болох байх. Тэгэхэд дор хаяж 1 орон тооны мэргэшсэн зөвлөхтэй бол байна.

Тэгээд яг татварын мэргэшсэн зөвлөгөө үзүүлээд явахад компани дээр, өөр компани дээр очоод үзүүлээд явахад өөрийнх нь татварын мэргэшсэн зөвлөгөө үзүүлэх гэрчилгээ, тамга тэмдгээ үзүүлээд тэрүүн дээр нь тамга дараад тухайн аж ахуйн нэгж нь хуулийн этгээд нь хуулийн дагуу хариуцлага хүлээгээд мэргэжлийн даатгалд хамрагдаад, тэгээд хэрвээ хариуцлага хүлээх юм бол бас даатгалаас нь үүнийг нь үйлчлүүлэгчийнх нь хохирлыг барагдуулдаг бид нар ийм тогтолцоо руу оруулж байгаа.

Ер нь бас энэ санхүүгийн тэр үйлчилгээнийг авчхаад бид, би ч гэсэн хувийн хэвшилд байж байхад мөнгөө

төлөөд, үйлчилгээ авчихсанахаа дараагаар ахиад татварын шалгалт оронгуут бөөн зөрчил илрүүлчихдэг. Тэгээд дараа нь тэр хохирлоо хэнээс барагдуулахаа мэдэхгүй. Уг нь аудитад баахан мөнгө төлөөд манай төсөв, санхүү, тайлан тооцоо болж байна уу, болохгүй байна уу гээд тэгэхээр баахан мөнгө төлж, баахан зөвлөгөө өгч өгчхөөд дараа нь тэгтэл аудит орохоороо, татварын шалгалт орохоороо ахиад ерөөсөө тэд нарын олж хараагүй баахан юмнуудыг илрүүлчихдэг.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор ер нь энэ санхүүгийн татварын, хуулийн энэ зөвлөх үйлчилгээнүүд бас нэлээн хариуцлагатай байх ёстой гэж бодоод байгаа юм. Тэгээд 2020 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлж байгаа манай Татварын багц хууль аж ахуйн нэгжүүд зарим нь жилд ганцхан удаа, зарим нь хагас жилд ганцхан удаа татвараа өгдөг, тайлангаа тушаадаг ийм хуулийг бид нар баталсан.

Тэгэхээр энэ хүрээнд бас бид нар юу гэж оруулж байна вэ гэхээр ялангуяа манай жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн хувьд та заавал нягтлантай байх албагүй. Ийм үйлчилгээг аваад, тайлан тооцоогоо гаргуулаад, санхүүгийнхээ тайлан бүртгэлүүдийг хийлгээд явна гэдэг үг нь хууль, эрх зүйн орчныг бий болгочоод одоо бид нар үйлчилгээг нь илүү сайн хуульчилж өгч байна гэсэн үг.

Гэхдээ үүнийг бас ингээд одоо чангалж болохгүй дээ, сургалт хийж болохгүй дээ гэхээсээ илүүтэйгээр нөгөө талдаа бид нар бас үйлчлүүлэгч талынхаа эрх ашгийг давхар хамгаалж байхгүй бол аягүй хэцүү юм байна лээ. Ер нь ялангуяа энэ хувийн хэвшлийнхэн сайн мэдэх байх. Мөнгө төлөөд л үйлчилгээ авч авчхаад л дараа нь ахиад л торгууль, алданги ингээд ноогдуулаад байдаг ийм үйлчилгээ эрхлэгчтэй болчих юм бол хуульчлаад бүүр энэ салбараа. Тэгэх юм бол бас нөгөө талынх нь эрх ашиг давхар

хангагдахгүй шүү гэдэг утгаараа л оруулсан юм.

**Г.Тэмүүлэн:** Нэмж тодруулъя Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Тусгай эрх авчихсан хуулийн этгээд салбартай байж болно. Тэр нь чадамжтай салбар л байх ёстой. Тийм учраас энд 1-ээс доошгүй энэ тэр гэж ярьж байсан дор бол үйлчлүүлэгчдэдээ татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй тэр л мэргэжилтнээрээ л үйлчилгээ үзүүл гэдэг л байх ёстой. Тэрнээс салбарт 1 байна уу, 3 байна уу тэр тоог бид хуулиар заагаад хэрэггүй.

Ерөөсөө уг эрх авсан хуулийн этгээд үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлж байгаа бол татварын мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх эрхтэй тэр мэргэжилтнээрээ л үйлчилгээ үзүүл гэдгийг нь энд хэлж өгөх ёстой бид. Тэгж байж энэ өөрөө чадамжтай болно. Яг сая манай ажлын хэсгийн ахлагчийн хэлж байгаа шиг энэ зөвлөх үйлчилгээ авчихсан компанид баахан татварын өр, төлбөр гардаггүй байх асуудал бол тэр үйлчилгээ үзүүлж байгаа улсуудын чадамжтай холбоотой зүйл байхгүй юу.

**Г.Тэмүүлэн:** Санал хураалт, тайлбар өгөх юм уу. 5 номер Болормаа Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга.

**Б.Болормаа:** Тийм 1 байгаа.

**Г.Тэмүүлэн:** Болормаа дарга тайлбар өгье.

**Б.Болормаа:** Тийм, гишүүний асуултад хариулъя. Одоо бол бид нар үндсэн орон тоон дээр 3 мэргэшсэн зөвлөхтэй байхыг шаардсан. Одоогийн хуулийн заалт тийм байдаг. Бид нар бол үндсэн орон тоон дээр 2 байхыг хөнгөвчилж өгч байгаа. Салбар дээр бол одоо яг ямар өөр үйл ажиллагаа явдаг гэхээр хөдөө орон нутагт л салбар байгуулж байгаа. Улаанбаатар хотод

үйл ажиллагаа явуулж байгаа байгуулагдсан компани орон нутагт салбараа байгуулчихдаг. Тэгээд салбар нь өөрөө яг ямар үйл ажиллагаа эрхэлдэг вэ гэхээр ямар ч мэргэжлийн хүнгүйгээр тэндээ ингээд тамга, тэмдэг дардаг ийм үйл ажиллагаа явуулаад байгаа юм.

Тэгэхээр Баян-Өлгийд байгаа юм уу, Ховдод байгаа салбар дээр болохоор мэргэжлийн хүн байхгүй. Яг энэ тусгай зөвшөөрөлтэй этгээд байхгүй болохоор зүгээр тамга дарах үйл ажиллагаа явагдах ийм процесс давамгайлаад байгаа учраас ядаж салбартаа хамгийн багадаа 1 тийм тусгай зөвшөөрөлтэй этгээд ажиллуулахыг бол шаардаж байгаа.

Ингэснээрээ бол Үндсэн төв, толгой компани дээрээ 2, тэгээд салбарт дор хаяж 1 байхыг шаардаж байгаа. Тэгэхээр цаанаа бол зайлиггүй мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй этгээд энэ үйлчилгээг үзүүлэх ёстой л гэдэг хатуу шаардлага явж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Хуулийнх нь томъёолол нь одоо өргөн мэдүүлснийг нь би уншаад үзүүлээдэхье. Өргөн мэдүүлсэн дээр нь бол хувьцаа эзэмшиг,

10.1.1 хувьцаа эзэмшигчийн гишүүний дийлэнх олонх, үүсгэн байгуулсан татварын мэргэшсэн зөвлөх байх.

10.1.2 нь хязгаарлагдмал хариуцлагатай компани бол 3, түүнээс доошгүй тооны хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл бол 2, түүнээс доошгүй тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх.

10.1.8 нь хязгаарлагдмал хариуцлагатай компани салбартай бол түүнд нэгээс багагүй орон тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх гэсэн юм байна. Нэгээс багагүй гэсэн.

Батжаргал гишүүн тодруулах уу. Санал хураалт явуулъя. Нэмж тайлбар өгөх байгаа юу, байхгүй юу. 6 номер.

**Ү.Галмандах:** Одоогийн хууль эрх зүйн орчин дээр бол яг мөрдөгдөж байгаа нь бол татварын орон тооны 3 татварын мэргэшсэн зөвлөхтэй байна. Салбартаа бол 2 татварын мэргэшсэн зөвлөхтэй байх гэдэг ийм шаардлага байгаа.

Ер нь бол энэ дээр нэг талаар бол хуулийн энэ тавигдаж байгаа энэ шаардлага бол яг энэ төдийлөн татварын зөвлөх үйлчилгээний компаниуд өсөж дэвжихгүй. Одоо өнөөдөртөө 40 компани л байгаа. 3 хүн нийлж компани байгуулахад. Тэгэхээр ийм хуулийн өндөр шаардлага тавигдаад байгаа учраас нөгөө талаараа ингэж тавьж өгч байгаа.

Нөгөө талаараа бол энэ татварын салбар дээр татварын мэргэшсэн зөвлөх хүн байж байж энэ тэнд үзүүлж байгаа тэр татвар төлөгчдийн эрх ашгийг хамгаалах юм байна гэдэг ийм шалгуурыг зайлшгүй тавьж өгөх ийм шаардлагатай болоод байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт .

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалтын 11.1.4 дэх заалт, 6 дахь заалтын 12.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11.1.4.үйлчлүүлэгчийн өмнөөс үйлдсэн, шалгасан татварын тайлан, холбогдох бусад баримт бичигт зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон орон тооны татварын мэргэшсэн зөвлөхийн эрхтэй албан тушаалтан гарын үсэг, эсхүл тоон гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах;”

12.2.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгох, сунгах бөгөөд энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал 58.3 хувиар дэмжигдлээ.

15.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 14.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14.5.Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг гурван түвшний зэрэглэлтэй олгох бөгөөд нэг, хоёрдугаар түвшний зэрэглэл тус бүрийг 5 жилийн хугацаагаар, гуравдугаар түвшний зэрэглэлийг хугацаагүй олгоно. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалт 58.3 хувиар дэмжигдлээ.

16.Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын 15.1.1, 15.1.2, 15.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

15.1.1.их, дээд сургуулийг нягтлан бодогч, эдийн засагч, санхүүч мэргэжлээр болон татварын чиглэлээр бакалавр, түүнээс дээш зэрэгтэй төгссөн, эсхүл 5-аас доошгүй жил их, дээд сургуульд татвар, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр багшилсан, татварын асуудал эрхэлсэн төрийн байгууллагад ажилласан байх;

15.1.2.нягтлан бодогч, эдийн засагч, санхүүч мэргэжлээр болон татварын чиглэлээр 4-өөс доошгүй жил ажилласан байх;

15.1.4.зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч нь зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд давхар үүсгэн байгуулахгүй байх. Санал гаргасан ажлын хэсэг.



*Батжаргал гишүүн тодруулъя.*

**Ж.Батжаргал:** Үгүй энэ чинь болох юм уу нөхдүүд ээ. Тодорхой улсуудад зориулаад хууль баталж өгөх гээд байгаа юм биш үү. Нэг бол их, дээд сургууль татварын чиглэлээр багшилсан бай, нэг бол төрийн татварын албанд ажилласан бай. Яагаад энэ нягтлан бодогч мэргэжлээр төгсчихсөн улсууд чинь энэ хамрагдах ёстой кредит сургалтдаа хамрагдаад татварын мэргэжсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхээ авч болохгүй байгаад байгаа юм. Ийм бүдүүлэг хууль хийж болохгүй шүү дээ. Наад 15.1.1 чинь яг тэгээд ороод ирж байгаа байхгүй юу.

Тэр одоо тэр сая өмнө санал хураалгасан энэ 11.1.4 бол яг нарийндаа тусгай эрх авчихсан хэдэн компани тэжээх гэж орж ирж байгаа заалт байхгүй юу. Гүйцэтгэх захирал юм уу, эс үгүй бол тэр мэргэжсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй хүн нь гарын үсэг зурж, тамга дарна гэж. Өөр өөрсдийнхөө зөвлөх үйлчилгээ үзүүлсэн зүйл дээр л хариуцлага хүлээдэг шүү дээ. Ийм дордуулсан эрх зүйн бүдүүлэг зохицуулалт нэг байгууллага тодорхой хэсэг хүмүүст зориулсан хууль баталдаг юмаа болих ёстой юм бид.

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсгийн дарга Булгантуяа асуултад хариулъя.

**Х.Булгантуяа:** Энэ уг нь Батжаргал даргаа яг л таны хэлээд байгаа саналыг уг нь оруулж байна шүү дээ. Их, дээд сургуулийг нягтлан бодогч, эдийн засаг, санхүүч мэргэжлээр мэргэжлээр болон татварын чиглэлээр бакалавраар төгссөн, эс үгүй бол тэрнээс дээш зэрэглэл бай гэхээр магистр, доктортой байж болно. Эс үгүй бол 5-аас доош жил их, дээд сургуульд татвар, нягтлан бодохын чиглэлээр багшилсан хүн байж болно. Эс үгүй бол татварын асуудал эрхэлсэн байгууллагад ажиллаж байсан байж болно гэдэг ийм хэдэн шалгуур энэ чинь аж ахуйн нэгжид, дээрээс нь нэмээд

төрийн өмчит компаниудад, дээрээс нь нэмээд Хөрөнгийн биржид арилжаалах гэж байгаа компаниудад зөвлөгөө үзүүлэх чиглэлийн хүмүүс байх ёстой гэхээр бид нар зүгээр компанийн тооцооны нягтлан, нярав сонгон шалгаруулахтай адилхан бас арай ч шаардлага нэгдүгээрт тавьж бас болохгүй байх.

Хоёрдугаарт тэр нөгөө таны хэлдэг тэр 11.1.4 гэдэг энэ яг Хөрөнгийн үнэлгээ, Аудитын хуулиуд дээр бас яг ийм байгаа юм.

Нэгдүгээрт, Заавал бид нар мэргэжлийн хүнтэй байх ёстой гэхээр тэр мэргэжлийн хүн өөрийнхөө мэргэжлийнхээ тамга тэмдгийг дарна. Мэдээж тэнд өөрөө дарахын тулд мэргэжлийн хүн өөрөө тэнд үйлчилгээгээ үзүүлнэ.

Дараа нь тэр хүний өөрийнх нь тамга тэмдэг дарсан, гарын үсэг зурсан юм нь хэрвээ буруу, зөрүү байх юм бол тэр хүн өөрийнхөө мэргэжлийн хариуцлагыг хүлээнэ, мэргэжлийнхээ тусгай зөвшөөрлөө алдана.

Дээрээс нь нэмээд компанийн гүйцэтгэх захирал гэхдээ магадгүй өөр мэргэжлийн хүн бас байж болно. Тэгэхдээ тэр аж ахуйн нэгжийнхээ өмнөөс даатгуулагчийн хариуцлага хүлээсэн учраас аж ахуйн нэгж нь нөгөө мэргэжлийн даатгалд даатгуулах ёстой байгаад байгаа юм. Тэгэхээр санхүүгийн хариуцлага хүлээж байгаа учраас бас давхар гарын үсэг зурна. Аж ахуйн нэгж ч гарын үсэг зурна, үйлчилгээ үзүүлсэн татварын мэргэжсэн зөвлөх бас гарын үсэг зурж, өөрийнхөө мэргэжлийнхээ тамга тэмдгийг дарна гэдэг.

Тэгэхээр тэгэхээр ийм мэргэжлийн нарийн мэргэжлийн хүн бол дор хаяж ийм мэргэжилтэй, туршилагатай байна гэж оруулж өгөөд байгаа юм. Тэгээд яах вэ, энийг эс үгүй бол бүүр чангатгана гэсэн үг үү, багасгана гэсэн үг үү би түүнийг нь сайн

ойлгосонгүй 15.1.1-ийг. Батжаргал гишүүнийхийг.

Тэгээд нягтлан бодогч, эдийн засагч, санхүүч мэргэжлээр болон татварын чиглэлээр 4-өөс доошгүй жилд ажилласан байх гээд энд бол аж ахуйн нэгжд татварын зөвлөгөө үзүүлдэг хүн бол ядаж ийм туршилагатай байхгүй бол компанийнхаа нягтлангаас доор байх юм бол ийм татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээгээс илүүдэх зүйл байхгүй шүү дээ. Аан, одоо хууль дээрээ бас л юу байгаа шүү дээ. Тэгэхдээ нөгөө шаардлагууд нь арай бага байгаа тээ. Зүгээр нягтлан бодогч л гэж байгаад байгаа юм. Тийм, тэгээд үүнийг нь арай жоохон өргөжүүлээд нягтлан бодогчоор, эдийн засагчаар, санхүүчээр, дээрээс нь багшилж байсан, дээрээс нь нэмээд татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ажилласан бас байж болно гээд арай жоохон шаардлагыг нь өндөр л болгож байгаа юм л даа.

**Г.Тэмүүлэн:** 15.1.1 дээр чинь хуучин өргөн баригдсан нь ийм зүйл байсан юм байна шүү дээ тээ. Их, дээд сургуулийг нягтлан бодогчийн мэргэжлээр бакалавр, түүнээс дээш зэрэгтэй төгссөн, мэргэжлээрээ 4, түүнээс доошгүй жил ажилласан ажлын туршилага, ур чадвартай байх гэдгийг нь их, дээд сургуулийг нягтлан бодогч, эдийн засагч, санхүүч мэргэжлээр болон татварын чиглэлээр бакалавр, түүнээс дээш зэрэгтэй төгссөн гэж арай суллаж өгч байгаа юм байна шүү дээ тээ.

Тэгээд давхар, эсхүл гэдэг бас гаргалгаа гаргаж өгч байгаа юм байна тээ. Би эхлээд бас энэ багшилсан болоод төрийн байгууллагад ажилласан гэдгийг нь гайхаж хараад байсан чинь эсхүл гээд 5-аас доошгүй жил их, дээд сургуульд татвар, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр багшилсан, татварын асуудал эрхэлсэн төрийн байгууллагад ажилласан байх гээд өргөн баригдсанаасаа нэг талдаа энэ чинь суллаж өгч байгаа л тийм юм байна тээ. За ойлголоо.

Энэ дээр саналтай хүн байна уу. Алга байна.

Санал хураалт 58.3 хувиар дэмжигдлээ.

Даваасүрэн гишүүн санал. Горимын санал гаргасан уу та. Даваасүрэн гишүүний микрофон өгье.

**Ц.Даваасүрэн:** Тэр миний өмнө хураалгасан 12.1.8-ыг дутуу тайлбарлачихсан байсан юм байна. Би тэгээд энэ дээр бас буруу ойлголт төрсөн байна шүү.

Тийм учраас би гаргасан саналаа буцаагаад татчихъя. Би ойлгохдоо энэ бол зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанийн тухай ярьж байна гэж ингэж ойлголоо. Тэрнээс биш бүх компаниуд биш юм байна шүү дээ тээ. Тэгвэл би буцаагаад татчихъя.

**Г.Тэмүүлэн:** Тэгвэл Даваасүрэн гишүүн саналаа буцаагаад татаж байна. Даваасүрэн гишүүн саналаа буцааж татсантай холбогдуулаад ажлын хэсгийн саналаар дахиж санал хураах юм байна. Тэр нь бол 5 дээр байгаа. Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 12.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах гээд,

12.1.8 нь хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, орон тооны татварын мэргэшсэн зөвлөх нь ёс зүйн зөрчилгүй талаарх Татварын мэргэшсэн зөвлөлийн, мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолт. Санал гаргасан нь ажлын хэсэг гэж байгаа юм байна. Үүгээр санал хураалт явуулж таарах юм байна. Санал татсантай холбогдуулж санал хураалт.

Санал 66.7 хувиар дэмжигдлээ.

17.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалтын 18.2.5, 18.2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

18.2.5. энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан этгээдийг мэргэжил, арга зүй, үйл ажиллагаандаа мөрдөх гарын авлага, татварын хууль тогтоомжийн талаарх мэдээллээр хангах, бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох мэдээллийг төрийн байгууллагад хүргүүлэх;

18.2.6. татварын тусгай мэдлэг бүхий шинжээчийг нийтэд мэдээлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

58.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг 2 саналтай юм байна. 2 саналыг уншиж танилцуулъя.

Нэг нь 18.Төслийн 4 дүгээр зүйлийн 13.3 дахь хэсгийг агуулгын хувьд нийцүүлэн, төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

13.3.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн орон тооны татварын мэргэшсэн зөвлөх ёс зүйн зөрчил гаргасан талаарх Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолт болон бусад этгээдээс мэдээлэл ирсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд түдгэлзүүлэх, хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ. Санал гаргасан ажлын хэсэг гэсэн байна. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

19.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг агуулгын хувьд нийцүүлэн төслийн 2 дугаар зүйл рүү шилжүүлж, “авахад” гэсний дараа “болон татварын мэргэшсэн зөвлөхийн эрхтэй холбогдсон харилцаанд” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалт 58.3 хувиар дэмжигдлээ.

20.Төсөл, хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг 1 саналтай байна.

20.Төслийн 5 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтыг агуулгын хувьд нийцүүлэн, төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт руу шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

12.1.6.хуулийн этгээд, түүний эцсийн өмчлөгч нь татварын өргүй талаарх тодорхойлолт. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төсөл ажлын хэсэг 1 саналтай байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн дагаж мөрдөх хугацааг 2024 оны 1 дүгээр сарын 1 -ний өдөр гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

58.3 хувиар дэмжигдлээ.

Найруулгын 2 санал байна. Найруулгын санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 биш ээ, 1 дүгээр зүйлийн “4.3, 4.4 дэх заалт” гэснийг “хэсэг” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн “хэсэг” гэсний өмнө “зүйл,” гэж нэмж, төслийн 4 дүгээр зүйлд заасан “зөвлөх үйлчилгээ эрхлэх” гэсний ард тохиолдол бүрт “хуулийн” гэж нэмж, “мөн зүйлийн 11.1 дэх хэсэг” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалт 58.3 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалт 58.3 хувиар дэмжигдлээ.

Санал хураалтыг явуулж дууслаа. Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Ажлын хэсэг, дэд ажлын хэсэг анхаараарай. Саяын 12 дахь саналын зөрүүтэй томъёолол буюу тэр 9.1 дүгээр заалт чинь үнэхээрийн марзан томъёололтой болчихсон шүү. Нэр томъёоны тодорхойлолтын хэлбэрээр үйл ажиллагаа явуулна гэж тийм үг байж болохгүй байлгүй дээ. 3.1.3 чинь нэр томъёолол л заасан шүү дээ биднүүс. Болохгүй ерөөсөө. Найруулгын хувьд наадхаа эргэж харахгүй бол болохгүй шүү.

**Г.Тэмүүлэн:** Энэ дээр эх барьсан зөвлөх болоод Байнгын хорооныхон, зөвлөхүүд ажиллаад зарчмын зөрүүтэй саналыг гаргаж танилцуулаад санал хураалгая. Агуулгын хувьд алдаатай тийм зүйл болсон байна. Тэгээд дараа нь найруулгаар бид нар бас авч болохгүй болчих байх.

**Г.Тэмүүлэн:** Булгантуяа ажлын хэсгийн ахлагч микрофоныг өгье. Санал гаргана.

**Х.Булгантуяа:** Батжаргал гишүүний сая гаргасан саналыг үндэслэн ажлын хэсгээс оруулсан 9 дүгээр зүйлийн зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд гэдгийн 9.1-ийн саналын томъёоллыг өмнөх саналын томъёоллыг татаж ийм байдлаар найруулъя гэж оруулж байна.

Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь зөвлөх үйлчилгээ, татварын мэргэжсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл байх бөгөөд бусад татварын мэргэжсэн зөвлөхтэй гэрээгээр хамтарч ажиллаж болно гэж. Тэгвэл ийм ингэж томъёолоод санал хураалт явуулж өгөөч. Өмнөх саналаа нэгдүгээрт татаад саяынхаар томъёолж санал хураалт явуулъя.

**Г.Тэмүүлэн:** Өмнө хураалгасан саналаа татаж байна гэсэн үг. Тэгэхээр санал хураалгах шаардлагагүй гэсэн үг тээ. Өмнөхөө хүчингүй болгоно. Санал хураачихсан учраас окэй. Тэгвэл ажлын хэсгээс гаргасан санал. 9 дүгээр зүйл зөвлөх үйлчилгээ эрх, энэ юм байна шүү дээ.

12.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын гарчиг болон 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

9 дүгээр зүйл. Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд

9.1.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.3-т заасан хэлбэрээр үйлчилгээ явуулах бөгөөд зөвлөх үйлчилгээ эрхлэхдээ бусад татварын мэргэжсэн зөвлөхтэй гэрээгээр хамтарч ажиллаж болно гэсэн. Энэ дэмжигдсэн саналыг хүчингүй болгох санал хураалтыг явуулах юм байна. Санал хураалт.

Санал хураалт 58.3 хувиар дэмжигдлээ. Энэ санал хүчингүй болгох санал дэмжигдсэн тул Булгантуяа гишүүний гаргаж байгаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Булгантуяа сайд саналаа гаргачих уу та. Булгантуяа сайд.

**Х.Булгантуяа:** 12 дугаар саналын түрүүний санал хураалт хүчингүй болсонтой холбоотойгоор 12 дугаар саналыг дараах байдлаар найруулан санал хураалт явуулж өгөөч гэж хүсэж байна.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын гарчиг болон 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

9 дүгээр зүйл. Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд

9.1.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл байх бөгөөд бусад татварын мэргэшсэн зөвлөхтэй гэрээгээр хамтарч ажиллаж болно.

**Г.Тэмүүлэн:** Булгантуяа гишүүний гаргасан саналыг дэмжье гэдэг саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

58.3 хувиар дэмжигдлээ.

Ингээд санал хураалтыг явуулж дууслаа.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн. Нэг юу нь үлдчихсэн юм байна. Уучлаарай.

Дагаж мөрдөх журмын тухай хууль нь хоцорсон юм байна. Ажлын хэсгийн саналаар байгаа юм байна.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай

1 дүгээр зүйл 2023 оны дугаар сарын тэдний өдөр баталсан Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө олгогдсон тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт заасан татварын мэргэшсэн зөвлөх эрхийг зэрэглэлд шилжүүлэх харилцааг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага журмаар зохицуулна.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын мэргэшсэн зөвлөх, мэргэшсэн зөвлөх нийгэмлэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан ажлын хэсэг гэсэн.

Дагаж мөрдөх, Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль юм байна. Ажлын хэсгийн ахлагч та энэ дээр тайлбар хэлэх үү. Яагаад энийг оруулах ёстой болсон юм бол. Ажлын хэсгийн ахлагч Булгантуяа.

**Х.Булгантуяа:** Одоо энэ хууль батлагдсантай холбоотойгоор одоогийн мөрдөж байгаа хууль дээр жишээлбэл хуулийн этгээдийг 3 мэргэшсэн зөвлөхтэй байхаар, дээрээс нь нэмээд бид нар бас энэ хууль дээр 1, 2, 3 дугаар зэрэглэл олгохоор энэ тэр гээд тусгай зөвшөөрлүүдийн үйлчлэл дээр бас нэлээдгүй өөрчлөлт оруулсан. Тэгэхээр 24 оны 1 дүгээр сарын 1-нээс энэ хууль хэрэгжиж эхлэхээс өмнө үүнтэй холбоотойгоор мэргэшсэн зөвлөхийн эрхийн зэрэглэлд шилжүүлэх, аж ахуйн нэгжүүдийг дахин зохион байгуулалтад оруулах гээд, тусгай

зөвшөөрлүүд олох гээд энэ асуудлуудыг зохион байгуулахаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яам журмаар зохицуулахаар энэ Дагаж мөрдөх журмын тухай хуулийг батлуулах шаардлагатай байгаа юм.

Ингэснээр энэ хууль 24 оны 1 дүгээр сарын 1-нээс бүрэн хэрэгжиж эхлэх боломжтой болох юм.

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо. Энэ асуудал дээр санал хураахгүй байна. Эцсийн хэлэлцүүлэг дээр санал хураалтыг явуулах юм байна. Ингээд санал хураалтыг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна. Хоёр дахь асуудалдаа оръё.

11.23 цаг

**Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.**

Танилцуулгыг Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг сайд танилцуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулж ирье. Чинзориг сайд. Карт өгөөрэй, Чинзориг сайдын картыг.

Чинзориг сайдын картыг өгөөрэй. Энэ хооронд ажлын хэсгийг танилцуулж байя.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2023 оны 6 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

Эрүүл мэндийн сайд Чинзориг, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна.

Чинзориг сайд танилцуулгаа хийе.

**С.Чинзориг:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье.

Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлд төсвийн жилд дамжин хэрэгжих арга хэмжээний зориулалт, хэсэгт тухайн төсвийн жилд ашиглагдаагүй үлдэгдлийг дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулж болохоор тусгагдсан байдаг. Мөн гэхдээ бас мөн хуулийн 7.7 дахь хэсэгт энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсөв захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үйлдлийг тухайн жилд шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7-гийн хэсэгт энэ хуулийн 7.7 дахь хэсэгт төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төсвийн захирагчид хамаарахгүй гэж заасан. Өөрөөр хэлбэл төрөлжсөн нэгдсэн эмнэлэг, аймгийн нэгдэн эмнэлэг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд энэ 7.9 дэх заалтаар төсвийн хөрөнгийн үлдэгдлийг нь төвлөрүүлэн татахгүй байх ийм заалт ороод хэрэгжиж байна.

Гэхдээ энэ заалтад эрүүл мэндийн анхан шатын тусламж үйлчилгээг иргэдэд хүргэж буй сум, тосгоны эрүүл эмнэлгийн төвийн асуудлыг тусгалгүй орхигдуулсан байна. Үүнээс болж жил бүрийн санхүүгийн тайланг аудитын шалгалтаар сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэгт энэ хуулийн 7.7 дахь хэсэгт төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төсвийн захирагчид хамаарахгүй гэж заасан нь сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд хамаарахгүй гэх үндэслэлээр дансны

үлдэгдлийг нь улсын төсөвт төвлөрүүлэх зөвлөмж, албан шаардлага байнга өгч байгаа болно.

Тийм учраас Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж 7.7 дахь хэсэгт төрийн өмчийн төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төсвийн захирагч гэдгийн дараа сум, тосгоны гэж нэмж өөрчлөлт оруулах ийм саналыг оруулж байна.

Ингэснээрээ сумын, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагууд төсвийн байнаа, төсвийнхөө үлдэгдлийг захиран зарцуулах эрхтэй болох, нөгөө талдаа эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа гүйцэтгэлийн санхүүжилтийн үр, гүйцэтгэл санхүүжилтийн арга бодит байдлаар хэрэгжих ийм нөхцөл боломж бүрдэнэ гэж үзэж байгаа юм. Ингээд Байнгын хорооны гишүүдийг Төсвийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг дэмжихийг хүсэж байна.

Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулсан.

Хуулийн төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Сандаг-Очир гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Энэ манай нийгмийн зарим салбарууд одоо ер нь бүгдээрээ ч болж байх шиг байна. Үр дүн, гүйцэтгэлийн санхүүжилтийн хэлбэр рүү шилжчихсэн. Үлдсэн мөнгөө өөрсдөө зарцуулах эрх ингээд олддог юм байж зохицуулаад. Гэтэл яаж зарцуулах юм гэдэг ерөнхий чиглэл тодорхойлогдоогүй, журамлагдаагүй.

Тийм учраас одоо орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд аймгийнхаа эрүүл мэндийн газраар дамжуулаад Эрүүл мэндийн яам руугаа хүсэлт тавьж байгаа. Манайх ийм хэмжээний үлдэгдэлтэй байна, энийг ийм ийм зүйлд

зарцуулах саналтай байна гээд ингээд ирүүлж байгаа. Тэгээд тэрний дагуу эндээс гэдэг юм уу, аймгийн эрүүл мэндийн газраас нь тодорхой хэмжээний чиглэл очдог байх. Тэгээд ингэж зарцуулагдаад байгаа юм.

Тийм учраас энэ үлдэгдэл хөрөнгөө ер нь яаж зарцуулах ёстой юм бэ гэдэг юмаа салбарынхаа түвшинд эрх зүйн зөв зохицуулалт хийж өгөхгүй бол энэ манай төсвийн асуудалдаа хяналт шалгалт хийдэг санхүүгийн хяналт шалгалтын байгууллагууд зарим дээр нь төлбөр тавиад үймүүлээд байгаа.

Тэгэхээр үүнийг нэг мөр зөв зохицуулах л тухай л асуудал байна уу л гэж би хараад байгаа юм. Энэ дээр манай Эрүүл мэндийн яам, сайд, энэ санхүүгийн асуудлаа хариуцаж байгаа төрийн захиргааны төв байгууллага ер нь ямар бодол, чиглэлтэй байгаа юм бэ. Энийг тодруулж асуумаар байна.

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн сайд Чинзориг сайд.

**С.Чинзориг:** Тийм, Батжаргал гишүүнтэй би үндсэндээ санал нэг байна. Одоогийн Төсвийн тухай хуульд байгаа заалтаар энэ төрөлжсөн томоохон эмнэлгүүд, аймгийн нэгдсэн эмнэлгүүд, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд бол гүйцэтгэлийнхээ санхүүжилтээр санхүүжилт үлдэгдэлтэй гарсан бол өөрсдөө захиран зарцуулах эрхтэй байгаа юм. Сум, тосгоны эмнэлгүүд ийм эрхгүй учраас захиран зарцуулах эрхгүй бол байгаа юм.

Гэхдээ энийг сая Батжаргал гишүүний ярьдагтай холбоотойгоор бас жоохон зохицуулалт хийж өгөхгүй бол зөвхөн цалин, хөлс нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр ашиглахаасаа илүүтэйгээр эмийн санхүүжилтэд түлхүү зарцуулах, дээр нь бараа бүтээгдэхүүн худалдан авах ийм зүйлд зарцуулах асуудал нэлээн түгээмэл байна. Шулуухан хэлэхэд бол.

Тийм учраас Сангийн сайдтай бид нар ярьж яг хуулийн зохицуулалтууд нь хэр болох нь, тодорхой хэмжээгээр энэ үлдэгдэл санхүүжилтийнхээ тэдэн хувийг нийгмийн баталгаа, цалин хөлсөө зарцуулж байх, тэдэн хувийг нь тэр эм, бараа бүтээгдэхүүн худалдан авахад зарцуулж бай гэсэн бас тийм журамлаж өгөхгүй бол дандаа нөгөө эм, бараа бүтээгдэхүүн худалдан авах зардал руу бас шилжээд байгаа асуудлууд байна.

Энийг би Сангийн яам яамтай бас ярьсан. Тэгээд яг одоо 2 сайдын тушаалаар бас зохицуулчихлаар бас хууль, эрх зүйн асуудал бас жаахан асуудал байна гэсэн ийм зүйл бас яриад байгаа юм. Тэгэхдээ яах вэ сая Сангийн сайдтай ярьж байгаад 2 сайдын тушаал гаргаад тодорхой тийм хязгаар бас тогтоохоос бас өөр арга алга гэсэн ийм бас байдал бол байгаа.

**Г.Тэмүүлэн:** Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

**Ц.Сандаг-Очир:** Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд ингээд зарцуулах эрх нь байхгүй учраас үлдэгдэлтэй гээд үлдэгдлийн хэрхэн, яаж зарцуулж чадахгүй гээд байгаа юм байна. Тэгээд энэ хууль батлагдсанаар тэр эрхийг нь нээж өгөх юм байна.

Ер нь энэ чинь төсвийн хэмнэлт биз дээ Чинзо сайдаа. Ер нь төсвийн хэмнэлт. Үлдэгдэл гээд байгаа энэ чинь үндсэндээ л нэг бол давалт, нэг бол хэмнэлт гээд. Төсвийн байгууллагууд дээр ямар орлого бүрдүүлж байгаа биш ямар давалт байх вэ. Тийм учраас хэмнэлт.

Уг нь бол энэ хэмнэлт гэдэг юм чинь байх ёстой юу, үгүй юу. Энэ чинь орон нутагт хэрэгцээ, шаардлага, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нөгөө 3, 4 төрлийн багц үйлчилгээгээ хэрэгжүүлээд л явж байгаа шүү дээ. Тэгээд л байнгын л хэрэгцээ, шаардлага бол сум дээр зөндөө л байгаа байх. Зүгээр та бүхний тооцоогоор мөнгөн хэлбэрээр хэдий

хэмжээний юм үлдчихээд байгаа юм. Энэ 22 оны төсвөөс сумууд дээр, тосгон дээр нийтдээ. Энэ 330 гаруй сум дээр чинь. Тэгээд тэрийгээ зарцуулах эрхээ нэхээд ингээд хууль, эрх зүйн орчин нь хаягдчихсан учраас зарцуулах эрхгүй болчихоод байгаа юм байна гэж ярьж байгаа юм.

Тийм учраас яах вэ, энэ Төсвийн хуульд өөрчлөлт оруулж байгаа юм байна. Энэ Хэмнэлтийн хуульд дагаж өөрчлөлт орох уу. Хэмнэлтийн хуулиар чинь ер нь энэ давсан юмнуудыг чинь бүгдийг нь 5 сарын 1-нээр Тендерийн хуулиудыг ингээд бүгдийг нь ингээд зарцуулах эрхийг нь хаачихсан байгаа шүү дээ. Татдаг болчихсон байгаа шүү дээ. Тэгэхээр энэ чинь дагаад бас Хэмнэлтийн хууль чинь өөрчлөлт орж ирэхгүй байсан юм уу Төсвийн хуулийг чинь дагаад. Энэ дээр юу гэж бодож байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Чинзориг сайд асуултад хариулъя.

**С.Чинзориг:** Одоогийн Төсвийн тухай хуулиар бол сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлийн санхүүжилтийн аргаар санхүүжилт аваад бас тодорхой хэмжээний санхүүжилтийн үлдэгдэлтэй гарвал өөрсдөө захиран зарцуулах эрхгүй, зайлшгүй төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлээд, тэгээд дараа оныхоо төсөвт зарцуулж байгаа ийм асуудлууд байгаа юм.

Дээр нь энэ захиран зарцуулах эрхгүй байна гээд аудитын газраас байнга бас зөвлөмж өгдөг, акт тавьдаг асуудлууд байгаа юм. Тухайлбал 2021 онд гэхэд 114 сая төгрөгийн акт аудитын байгууллагаас тавьсан байна лээ.

2022 онд 1.4 тэрбум төгрөгийн бас акт Төсвийн тухай хууль зөрчсөн байна гэсэн ийм бас акт тавьж, зөвлөмж өгсөн ийм асуудлууд байх юм. Яах вэ, манай орон нутгийн эрүүл мэндүүд ,сумын эрүүл мэндийн



байгууллагууд бол нөгөө гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжилт авч байгаа учраас хүн амынхаа тоо, төвөөс алслагдсан байдлаасаа хамаараад санхүүжилтийн үлдэгдэлтэй гарч байгаа асуудлууд нь бол маш ихялгамжтай.

Гэхдээ яах вэ бас 2022 оны жилийн эцсийн байдлаар 10 гаруй тэрбум төгрөгийн төсвийн үлдэгдэлтэй гарсан байна лээ. 330 сум тусахад бол. Нийт сумууд, сумын эрүүл мэндийн байгууллагуудын 70 хувь нь бас л тодорхой хэмжээний бас үлдэгдэлтэй гарсан байна гэсэн ийм тооцоо, судалгаа байх юм.

Тэгээд энийгээ өөрсдөө захиран зарцуулж чадахгүй, аудит акт тавьдаг, ингээд дандаа энэ тэгээд дандаа санхүүгийн жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангаар гарахлаар ингээд санхүүгийн зөрчилтэй гэсэн ийм асуудлууд гараад байгаа. Энийг нь бас нээгээд өгье яах вэ тэгээд бусад аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүрэг, төрөлжсөн эмнэлгүүд нь адил ингээд төсвийн зарц... нь бас эрхтэй байгаа учраас ингээд ижил түвшинд авч үзье гэж.

Хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудлыг бид нар хөндөөгүй. Хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал бол энэ Төсвийн хуульд өөрчлөлт орсноор бол өөрчлөлт оруулах шаардлагагүй ч бид үзсэн.

Харин эртүүдийн Төсвийн тодотголтой холбогдуулаад бас Хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулсан. Зарим нэг тодорхой хязгааруудыг бас нэлээн өөрчилсөн. Зарим дарга нарын унаа, унааны зардалтай холбоотой, албан тушаалтны унааны зардалтай холбоотой, машин худалдаж авахтай холбоотой асуудал бас жаахан энэ чинь арай бас жаахан өргөн хүрээгээр бас зохицуулсан шүү дээ.

Тийм учраас энэ төсвийн тухай Хэмнэлтийн хуультай бол зөрчилдөх юм байхгүй гэж үзэж байна.

**Г.Тэмүүлэн:** Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

**Ц.Сандаг-Очир:** Сайдын ярианд зөрчилтэй яриа байна. Акт тавигдсан гээд байна. Үлдэгдэл 10 орчим гаруй тэрбум төгрөг байгаа юм байна. 1.4 орчим тэрбум төгрөгийн акт тавигдсан байна.

Тэгэхээр энэ сумын өрхийн эрүүл мэндийн байгууллага чинь зарцуулчаад тэгээд тэр нь аудитын байгууллагадаа зөрчил болчихоод байна даа. Тэгэхээр эрх мэдлээ хэтрүүлж ашиглахчаад, хэтрүүлчээд тэр нь акт тавигдчихаад байгаа юм байна гэсэн үг юм байна тийм үү. Тэгж ойлгож болох уу.

**Г.Тэмүүлэн:** Чинзориг сайд хариулах уу.

**С.Чинзориг:** Тийм. Одоогийн төсвийн хуулиар бол аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүрэг, төрөлжсөн эмнэлгүүд нь бол санхүүгийн үлдэгдлээ захиран зарцуулах эрх нь нээгдчихсэн.

Сум, тосгоны эрүүл мэндийн байгууллага дээр үлдэгдэл хөрөнгөө захиран зарцуулах эрх нь нээгдээгүй учраас давсан хөрөнгөө захиран зарцуулахлаар Төсвийн тухай хуулиар танайд эрх олгогдоогүй байна гээд ингээд Төсвийн тухай хууль зөрчиж байна гээд ингээд аудитын байгууллага бол акт тавиад байгаа асуудал бол байх юм.

Харин зүгээр Сангийн яам бол харин төвлөрүүлэн татахгүй сүүлийн 2 жил бол нөгөө гүйцэтгэлийн санхүүжилтийн арга хэрэглэж байгаа учраас гээд бас салбарынх нь санхүүжилтийн онцлогийг олоод Сангийн яам бол төвлөрүүлэн татахгүй яваад байгаа.

Харин аудит болохлоор төсвийн хуулиар ийм эрх олгогдоогүй байна гээд

ингээд акт тавиад байгаа ийм зөрчлийн асуудал бол байгаад байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Хуулийн төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Санал хураалтыг явуулж эхэлье.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нь дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Ингээд хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир гишүүн та танилцуулах уу. Сандаг-Очир гишүүнээр танилцуулъя. Сандаг-Очир гишүүн танилцуулна.

Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. Гурав дахь асуудалдаа орё.

11.39 цаг

**Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.**

Хуулийн төслийн хамт 13 хууль Улсын Их Хурлын тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн байгаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд гишүүн тухайн төслийн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно гэж заасан байгаа.

Ингээд хууль болон Улсын Их Хурлын тогтоол төслүүд дээр санал хураалтыг явуулж эхэлье.

1.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалттай явуулъя хуулийн төсөл нь 6 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8.1.1<sup>1</sup> дэх заалтын дугаарыг “8.1.2” гэж, мөн зүйлийн 3 дахь заалтын 8.4.7<sup>1</sup> дэх заалтын дугаарыг “8.4.8” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан. Ингээд 1 дэх нь санал гаргасан, дугаар өөрчилж байгаа асуудал байгаа. Санал гаргасан Г.Тэмүүлэн. За тэгье. 8.4.8 гэж тус тус өөрчлөх гээд 1 дэх санал Төсвийн байнгын хороо санал гарч байгаа. Санал хураалт.

75 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 10.5 дахь хэсгийн “санхүүжүүлэх, хянах, тайлагнахад төслийн кодыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчид бүртгэж, төсвийн төлөвлөлтөд тусгана” гэснийг “санхүүжүүлэх, хянах, тайлагнах болон төрийн болон орон нутгийн өмчид бүртгэхдээ төслийн кодыг үндэслэн” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн, хэсгийн дугаарыг “11<sup>1</sup> дүгээр зүйл” болгон өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт. Хүлээж байгаарай. Хүлээж байгаарай алдаатай байна. Түр. Алдаатай байна шүү. Энэ санал хураалт хүчингүй болгоё. Уншиж танилцуулъя.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн, хэсгийн дугаарыг “11<sup>1</sup> дүгээр зүйл” болгон өөрчлөх:

**“11<sup>1</sup> дүгээр зүйл.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

11<sup>1.1</sup>.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 12<sup>2.1</sup>-д заасны дагуу боловсруулсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.”. Санал хураалт.

Санал хураалт 58.3 хувиар дэмжигдлээ.

Ганбаатар гишүүн, Пүрэвдорж гишүүн эсрэг гарч ирж байна.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 12.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн, хэсгийн дугаарыг “12<sup>2</sup> дугаар зүйл” болгон өөрчлөх:

**“12<sup>2</sup> дугаар зүйл.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

12.1.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулна.”. Санал хураалт.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 24.7 дахь хэсгийн “өмчийн оролцоотой” гэсний өмнө “, төрийн болон орон нутгийн” гэж, мөн хэсгийн “ногдох хөрөнгийг” гэсний өмнө “болон орон нутагт” гэж тус тус нэмэх. Санал

гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 27.1.10 дахь заалтын “ирээдүйн өв сангийн дансны үлдэгдлийн мэдээллийг” гэснийг “Ирээдүйн өв сангийн үлдэгдлийн хэмжээг” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

Энэ санал дэмжигдсэнгүй. Тогтохсүрэн, Сандаг-Очир гишүүн. Тогтохсүрэн дарга санал гаргая.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Би сая дэмжиж санал өгсөн юм. Саяын зарчмын зөрүүтэй саналыг. Тэгсэн чинь миний юу эсрэг гарчихсан байна. Тийм учраас дахин санал хураалт явуулж өгөөч гэж.

**Г.Тэмүүлэн:** Тогтохсүрэн гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Ингээд энэ сая хүч санал хүчингүй болсон тул саяын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

Энэ санал 66.7 хувиар дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1.2</sup> дахь хэсгийн “жил бүрийн 3, 8 дугаар сард багтаан” гэснийг “8 дугаар сард, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо.

Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1.2.1</sup> дэх

заалтын “асуудал” гэсний өмнө “салбарын гэж нэмэн, 28<sup>1</sup>.2 дахь заалтын, 28<sup>1</sup>.2.2 дахь заалтын “нийгмийн халамж, эрүүл мэнд, дэд бүтэц, байгаль орчин зэрэг” гэснийг болон 28<sup>1</sup>.2.3 дахь заалтын “зэрэг шинжтэй” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Төсвийг байнгын хороо. Санал хураалт.

75 хувиар дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1</sup>.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28<sup>1</sup>.3.Энэ хуулийн 28<sup>1</sup>.2-т заасан төсвийн тодотголд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэлээр боловсруулах төсвийн тодотгол хамаарахгүй.”. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

75 хувиар дэмжлээ.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1</sup>.4 дэх хэсгийн “төсөл, түүний нэмэлт, өөрчлөлтийн” гэснийг хасаж, “3 дугаар сард багтаан энэ хуулийн 28<sup>1</sup>.1-д заасан журмаар” гэснийг “3 дугаар сард багтаан, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд энэ зүйлд заасан журмаар” гэж өөрчлөх. Санал хураалт, санал гаргасан Төсвийн байнгын хороо.

66.7 хувиар дэмжигдлээ.

11.Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалт буюу 32.2.22 дахь заалтын “шийдвэрлэсэн талаар танилцуулгад тусгана.” гэснийг “тусгасан талаарх мэдээлэл;” гэж өөрчлөх. Санал хураалт, санал хураалт.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

12.Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсгийг хасаж, 70.2 дахь хэсгийн “гүйцэтгэх удирдлага болон холбогдох” гэснийг удирдах болон гүйцэтгэх” гэж, мөн хэсгийн “28<sup>1</sup>.3” гэснийг “28<sup>1</sup>.4” гэж өөрчлөх. Санал хураалт.

75 хувиар дэмжигдлээ.

13.Төслийн 2 дугаар зүйлийн “28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн “28.3.8” гэсний дараа “, 28.3.12” гэж,” гэснийг хасаж, ““санхүүжилтийн эх үүсвэрээр” гэсний дараа “анхны төсөвт өртөг, код” гэж” гэснийг ““төсөвт өртөг,” гэсний дараа “анхны төсөвт өртөг,” гэж” гэж өөрчлөх. Санал хураалт. Санал гаргасан Төсвийн байнгын хороо.

Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлийн 55 дугаар зүйлийн 55.4.2 дахь заалтын “ирэх” гэсний өмнө “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан” гэснийг хасах. Санал хураалт.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

15.Төслийн 3 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 8.1.1, 8.4.3, 8.4.4, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг” гэснийг “дараах хэсэг, заалтыг” гэж өөрчлөх. Санал хураалт, санал боловсруулсан Төсвийн байнгын хороо.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

16.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 8.1.1 дэх заалтын “боловсруулсан” гэснийг “ирүүлсэн” гэж, “дүн шинжилгээ, тооцоонд” гэснийг “таамаглалд” гэж тус тус өөрчлөн, 2 дахь заалт буюу 8.4.3 дахь заалтын “, шаардлагатай тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл

тухайн жилийн төсөвт баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг тус тус боловсруулж” гэснийг хасах.

Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

17.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 8.4.4 дэх заалтын “холбогдох макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тулгуурлан нэгтгэн боловсруулж, хөгжлийн бодлогын баримт бичигт нийцсэн эсэхэд эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж” гэснийг “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн нэгтгэн боловсруулж, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалт гацаад байна. Санал хураалт явуулъя. Санал хураалт энэ техник рүү хэлээрэй. Санал хураалт явахгүй байна. Санал хураалт техникийн саатал гарсан байна. Гишүүд анхааралтай байгаарай.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд алга байна.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гарах гишүүд байна уу. Алга байна.

4 дүгээр зүйл дээр 4-н заалт байна.

18.Төслийн 4 дүгээр зүйлийн “10-ны” гэснийг “9-ний” гэж өөрчлөн, “8.4.3

дахь заалтын “8 дугаар сарын 15-ны” гэснийг “07 дугаар сарын 25-ны” гэж, гэснийг хасах. Санал хураалт.

Санал хураалт, санал хураалт гацаад байх шиг байна. Техникийн алба анхаараарай. Санал хураалт явж байна. Гишүүд санал хураалт.

Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

19.Төслийн 4 дүгээр зүйлийн “чуулган эхлэх өдрөөс эхлэн хэлэлцэн” гэснийг чуулганаар хэлэлцэн” гэж өөрчлөх. Санал хураалт. Санал хураалт Төсвийн байнгын хороо.

75 хувиар дэмжигдлээ.

20.Төслийн 4 дүгээр зүйлийн “28 дугаар зүйлийн” гэснийг “28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн “28.3.8-д” гэснийг “ 28.3.8, 28.3.12-т” гэж, мөн зүйлийн” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт

Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

21.Төслийн 4 дүгээр зүйлийн “28.2,” гэснийг хасаж, “28.1” гэснийг “29.1” гэж өөрчлөн, “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “8 дугаар зүйлийн 8.1.2-8.1.4 дэх заалтын дугаарыг “8.1.3-8.1.5” гэж, 8.4.8 дахь заалтын дугаарыг “8.4.9” гэж” гэж нэмэх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

75 хувиар дэмжигдлээ.

12-т. Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

22.Төслийн 6 дугаар зүйлийн “хэсгийг” гэснийг “заалтыг” гэж өөрчлөх. Санал хураалт, Төсвийн байнгын хороо.

Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

Хоёр.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай төслийн талаар санал хураалт явъя.

Хуулийн төсөл 2 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Байнгын хорооноос 1 санал байгаа.

**Төсвийн байнгын хороо гаргасан,** Төслийн 1 дүгээр зүйлийн “түүний” гэснийг хасаж, “кодоор” гэснийг “бүрийн код” гэж өөрчлөх. Санал хураалт.

Санал хураалт. Тийм байна, гацаатай байх шиг байна. Санал хураалт. Техникийн алба анхаараарай. Санал хураалт гацаад байна. Дахиад хэлье санал хураалт.

75 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

Гурав.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явъя, явуулъя.

Хуулийн төсөл 3 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Байнгын хорооноос 1 санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн “хэлэлцээр батлахаас” гэснийг “хэлэлцээрээс” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

Техникийн алба анхаараарай. Дахиад санал хураалт. Санал хураалт. Техник гацаатай байна.

75 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж Байнгын хорооноос 1 санал байгаа.

Төслийн 2 дугаар зүйлийн “38.8 дахь” гэснийг “38.9 дэх” гэж өөрчлөх. Санал хураалт.

75 хувиар дэмжигдсэн байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулъя. Хуулийн төсөл 3 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Байнгын хорооноос 4 саналтай байгаа.

Төслийн 1 дүгээр зүйл буюу 75<sup>1</sup> дүгээр 75<sup>1</sup>.3.1 дахь заалтын “зээлийн зориулалт нь” гэснийг “зээлийн зориулалтыг тодорхой тусгасан эсэх”

гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

75 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйл буюу 75<sup>1</sup> дүгээр 75<sup>1</sup>.3.2 дахь заалтын “төсөл, арга хэмжээг хөгжлийн зорилтот хөтөлбөртэй нийцсэн эсэх” гэснийг “төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан, тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн төсөл, хөтөлбөр байх”. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйл буюу 75<sup>1</sup> дүгээр 75<sup>1</sup>.3.3 дахь заалтын “Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан төсөл, арга хэмжээ нь эдийн засгийн бодит өсөлтийг нэмэгдүүлэх” гэснийг “улс орны нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, импортыг орлох болон экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт болон зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэгдсэн байх” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

75 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйл буюу 75<sup>1</sup> дүгээр 75<sup>1</sup>.3.4 дэх заалтын “нөлөөлөхгүй” гэсний дараа “, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн” гэж нэмэх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт явж байна.

75 хувиар дэмжигдлээ.

Одоохон одоохон байж байгаарай. Сая хураасан чинь Дэгийн тухай хууль.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуух гишүүд байна уу. Алга байна.

Тав.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулъя.

Хуулийн төсөл 2 зүйлтэй байгаад байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Зургаа.Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулъя. Хуулийн төсөл нь 2 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Долоо.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулъя. Хуулийн төсөл 4 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Байнгын хороо 3 саналтай байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт” гэсний өмнө “хэсэг,” гэж нэмэн, мөн

зүйлийн 2 дахь заалт буюу 6.4.8 дахь заалтын “зардлын хяналтыг” гэснийг “гүйцэтгэлийн хяналтыг” гэж өөрчлөн, 3 дахь заалт буюу 6.5.3 дахь заалтын “хэлэлцээр” гэсний өмнө, 5 дахь заалт буюу 13.2.5 дахь заалтын “хэлэлцээрийн” гэсний өмнө “гэрээ,” гэж тус тус нэмэх. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6.5.4 дэх заалтын “Монгол Улс шинээр зээл авах” гэснийг “энэ хуульд заасны дагуу улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгаанд хамаарах зээл авах” гэж, мөн заалтын “зэрэг мэдээллийг нэгтгэсэн байдлаар” гэснийг “зэргийг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалт.

Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 18.11, байж байгаарай.

Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 18.11 дэх хэсгийн “тооцоолол” гэснийг “тооцоо, судалгаа” гэж өөрчлөн, “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн” гэсний өмнөх “Монгол Улсын шадар сайд,” гэснийг хасах. Санал хураалт.

Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. 2 дээр 1 санал байна.

Төслийн 2 дугаар зүйлийн “13.2.3” гэснийг “13.2.2” гэж өөрчлөх. Санал хураалт.

Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. 1 санал байна.

Төслийн 3 дугаар зүйлийн “тогтоосон” гэсний өмнө “талаар” гэж, “дэлгэрэнгүй” гэсний өмнө “талаарх” гэж тус тус нэмэх. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Найм.Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулъя. Хуулийн төсөл 4 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. 1 санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн “хэсэг” гэсний дараа “, заалт” гэж нэмэн, мөн зүйлийн 1 дэх заалт буюу 8.8 дахь хэсгийн “Монгол Улсын нэгдсэн төсвийн” гэснийг “Нэгдсэн төсвийн” гэж өөрчлөх. Санал хураалт.

Найруулгын л саналууд байна даа.

58.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. 1 санал байна.



Төслийн 3 дугаар зүйлийн ““өргөн мэдүүлсэн” гэснийг “өргөн мэдүүлэх” гэж” гэснийг “Монгол Улсын жилийн төсвийн” гэсний болон “жилийн төсвийн төсөлд” гэсний өмнөх “өргөн мэдүүлсэн” гэснийг “өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх” гэж” гэж өөрчлөх. Санал хураалт. Найруулгын саналууд байна.

58.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. 1 санал байна.

Төслийн 3 дугаар зүйлийн ““өргөн мэдүүлсэн” гэснийг “өргөн мэдүүлэх” гэж” гэснийг “Монгол Улсын жилийн төсвийн” гэсний болон “жилийн төсвийн төсөлд” гэсний өмнөх “өргөн мэдүүлсэн” гэснийг “өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх” гэж” гэж өөрчлөх. Санал хураалт.

75 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Ес.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя.

Хуулийн төсөл 3 зүйлтэй байгаа. 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

1 дүгээр зүйл дээр, 1 дүгээр зүйл дээр 11 санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн “, заалт” гэснийг хасаж, мөн зүйлийн 1 дэх заалт буюу 6.5 дахь хэсгийн “эцсийн хугацааг” гэснийг “хугацааг” гэж, мөн

зүйлийн 2 дахь заалт буюу 7.5 дахь хэсгийн “3 сараас доошгүй хугацаанд төсвийн төсөл” гэснийг “гурваас доошгүй сарын хугацаанд жилийн төсвийн төсөл” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт, санал гаргасан Төсвийн байнгын хороо.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7.6 дахь хэсгийн “Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гамшиг бүхий нөхцөл байдал бий болж төсөв болон” гэснийг “Гамшигийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгах зорилгоор жилийн төсөв болон” гэж өөрчлөх. Санал хураалт.

Энийг уншаад танилцуулаадахъя. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7.7 дахь хэсгийн “хэлэлцэх Улсын Их Хурлын байнгын хорооны хуралдаан болон нэгдсэн чуулганд нийт гишүүн хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэй нь тооцно.” гэснийг “хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.20-д зааснаас бусад тохиолдолд чуулганы хуралдаанд товлосон хугацаанд заавал хүрэлцэн ирж оролцоно.” гэж өөрчлөх. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16<sup>1</sup>.1 дэх хэсгийн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн” гэснийг “улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний” гэж, “үзүүлэлтийн төсөөллийг” гэснийг “үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 1 зүйлийн 4 дэх заалт буюу 16<sup>1</sup>.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16<sup>1</sup>.2.Зөвлөл нь 7 гишүүнээс бүрдэх бөгөөд Төсвийн байнгын хороо

нээлттэй сонгон шалгаруулалтаар хүн тус бүрээр шалгаруулж, Улсын Их Хурал энэ хуульд заасан журмын дагуу томилж, чөлөөлнө гэх нь байна шүү дээ тээ. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ. Төслийн.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16<sup>1</sup>.3.2 дахь заалтын “идэвхтэй” гэснийг, 16<sup>1</sup>.3.3 дахь заалтын “улс төрийн” гэснийг тус тус хасах. Санал хураалт.

75 хувиар дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16<sup>1</sup>.4.4 дэх заалтын “үр дүнгийн талаар сонсгол зохион байгуулж хамгийн өндөр үнэлэмж авсан” гэснийг “үр дүнд хамгийн өндөр үнэлгээ авсан” гэж өөрчлөх. Найруулга маягтай саналууд байна даа. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэн, үүнтэй уялдуулан 16<sup>1</sup>.4.5, 16<sup>1</sup>.4.6, 16<sup>1</sup>.4.7, 16<sup>1</sup>.4.8 дахь заалт, 16<sup>1</sup>.5, 16<sup>1</sup>.6 дахь хэсгийг тус тус хасах:

“16<sup>1</sup>.4.5.Төсвийн байнгын хороо нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29, 30, 31 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-127 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулах. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16<sup>1</sup>.8 дахь хэсгийн “Төсвийн байнгын хорооны шийдвэрээр” гэснийг “Улсын Их Хурал” гэж, 16<sup>1</sup>.9 дэх хэсгийн “үзүүлэлтийн тооцоолол” гэснийг “үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг” гэж тус тус өөрчлөн, уг хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“16<sup>1</sup>.6.7.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон. Санал хураалт.

75 хувиар дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16<sup>1</sup>.11 дэх хэсгийн “тогтоох итгэлцүүрийг” гэснийг болон 16<sup>1</sup>.12 дахь хэсгийг тус тус хасаж, 16<sup>1</sup>.3.7 дахь заалтын дугаарыг “16<sup>1</sup>.10.” гэж өөрчлөх. Санал хураалт. Санал гаргасан. Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 2 дугаар зүйл дээр 1 байна.

Төслийн 2 дугаар зүйлийн “үзүүлэлтийн төсөөлөлд” гэснийг “үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд” гэж өөрчлөх. Санал хураалт. Дуусаж байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гарах гишүүд байна уу. Алга байна. Энэ дээр бас Байнгын хороо анхаараарай, ажлын албаныхан. Найруулгын шинж чанартай зүйлүүд байгаа учраас заалтуудыг нэгтгээрэй. Их олон саналууд хураагдаж байна.

Арав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя. Хуулийн төсөл 2 зүйлтэй.

Энэ хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчим зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Арван нэг. Ирээдүйн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя. Хуулийн төсөл 3 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. 1 санал байна. Байнгын хорооноос.

Төслийн 1 дүгээр зүйлийн “8 дугаар зүйлийн 8.3 дахь” гэснийг “8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.5 дахь” гэж өөрчлөн, 8.3 дахь хэсгийн “дансанд” гэсний дараа “Сангийн эх үүсвэрийг” гэж нэмэх. Санал хураалт.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

Төслийн 2 дугаар зүйлийн “10.7, 10.8,” гэснийг “10 дугаар зүйлийн 10.8, 10.9 дэх хэсэг” гэж, мөн зүйлийн “24.15.5” гэснийг “25.14.5” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Арван хоёр. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя. Хуулийн төсөл 4 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. 1 санал байна. 2 санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн “15, 16, 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг” гэснийг “хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг” гэж өөрчлөх. Санал хураалт. Энэ дандаа найруулгын л

юу байна. Дараа нэгтгээд санал хураалгаарай Их Хурал дээр.

Энэ санал хураалт дэмжигдсэнгүй. Ганбаатар гишүүнийх эсрэг гарсан байна. Та санал гаргачих уу. Ганбаатар гишүүн.

**С.Ганбаатар:** Техникийн байдлаас болоод дахин санал хураалгаж өгнө үү.

**Г.Тэмүүлэн:** Саяын санал хураалтыг хүчингүй болгох Ганбаатар гишүүний саналыг дэмжье гэснээр санал хураая. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай.

66.7 хувиар дэмжигдлээ.

Саяын санал дэмжигдсэн тул, Ганбаатар гишүүний санал дэмжигдсэн тул 1 дэх заалтыг санал хураалтыг явуулъя дахин. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт буюу 5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “зэргээр аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг,” гэснийг “түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг” гэж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “төсвийн алдагдал нөхөх зэрэг аливаа хөтөлбөр, арга хэмжээг” гэснийг “болон төсвийн алдагдлыг” гэж тус тус өөрчлөн, мөн хэсгийн болон 3 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21 дэх хэсгийн “тусламж” гэсний дараа “, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ,” гэж тус тус нэмэн, 21 дэх хэсгийн “төсвийн алдагдал нөхөх зэрэг аливаа хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг” гэснийг “төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг” гэж өөрчлөх. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Арван гурав.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя. Хуулийн төсөл 2 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. 1 санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах, төсвийн цаглаврыг мөрдүүлэхтэй холбогдсон зүйл, хэсэг заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар төсөлтэй холбогдуулж санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Арван дөрөв.Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй байна. 1 санал байна.

Тогтоолын төслийн 1 дэх заалтын “16<sup>1</sup>.4 дэх” гэснийг “16<sup>1</sup> дүгээр зүйлийг” гэж өөрчлөх. Санал хураалт.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

Ингээд зарчмын зөрүүтэй санал хураалтыг явуулж дууслаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганд миний бие танилцуулъя.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн чуулганы хурал, Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

Идэвхтэй оролцсон Байнгын хорооныхоо гишүүддээ баярлалаа.

12.27 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

